



ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ
ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ
ТӨСӨЛ

ХӨГЖЛИЙН ЭЗЭД ТББ

УДИРТГАЛ

Монгол Улсын уул уурхайн салбар нь аж үйлдвэрийн салбартаа төдийгүй нийт эдийн засагт зонхилох байр суурийг эзэлдэг эдийн засгийн гол салбаруудын нэг билээ. Өнгөрсөн 17 жилийн дотор Монгол улсын алтны үйлдвэрлэл асар хурдацтай хөгжсөн бөгөөд бараг 30 дахин нэмэгдсэн байна. 1990-ээд оны дунд үеэс хэрэгжиж эхэлсэн “Алт” хөтөлбөр энэхүү үсрэнгүй хөгжилд жинтэй хувь нэмэр оруулснаас гадна гадаадын хөрөнгө оруулалтын дүнд 2008 онд алт үйлдвэрлэлтийн хэмжээ 15,2¹ тоннд хүрсэн байна.

Тус салбарын Монгол улсын ДНБ-д эзлэх хувь 2002 онд 10 хувь байсан бол сүүлийн 5 жилд 3 дахин нэмэгдэж 2008 оны байдлаар 28,2 хувьд² хүрээд байна. Мөн уул уурхайн салбар 42 мянга гаруй (буюу нийт ажиллах хүчний 4 гаруй хувь) хүнийг ажлын байраар хангаж, Монгол улсын экспортын нийт орлогын ¼-аас илүүг бүрдүүлж байна.

2003 оны Дэлхийн банкнаас³ хийсэн судалгаагаар Монгол улсад 100,000 гаруй гар аргаар алт олборлогч иргэд байдаг бөгөөд тэд жилд дунджаар 100 сая гаруй долларын алт зарж борлуулж байна гэсэн тооцоог хийсэн байдаг. Харин 2008 онд Ашигт малтмалын газраас⁴ гаргасан мэдээллээс харахад манай улсын 18 аймгийн 100 гаруй цэгт 54,000 гаруй хувиараа ашигт малтмал олборлогч нар үйл ажиллагаагаа явуулж байгаа талаар өгүүлсэн байна. Нийт хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн 90% нь алтны үндсэн ба шороон ордонд ажиллаж байна. Гэхдээ энэ төрлийн үйл ажиллагааг хэдэн хүн эрхэлж байгаа талаар тодорхой мэдээлэл, судалгаа байдаггүй нь тэдний эрхэлж байгаа үйл ажиллагааны онцлог болох алтны гарц, нөөц, түүнийг дагасан шилжилт хөдөлгөөний урсгалтай шууд холбоотой юм.

Энэхүү Борнуур сумын хувиараа алт олборлогч иргэдийн нийгэм эдийн засгийн суурь судалгаа нь тус суманд хувиараа алт малтмал олборлож буй иргэдийн амьжиргааны түвшин, алт олборлолт ба ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа байдал, тэдний орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, эрүүл мэнд болон нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, хувиараа алт олборлогч иргэдийн хамтын ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг тодорхойлох зорилгоор хийгдлээ.

Уг судалгаа нь мэдээлэл цуглуулах тоон аргачлалаас гадна оролцогч талуудын төлөөллийг оролцуулсан чанарын судалгааны арга зүйг ашиглан

¹ АМГ-Уул уурхайн салбарын үйл ажиллагааны тайлан 2008 он

³ Overview of ASM in Mongolia, Murray Harrison Ltd & Eco-Minex International Co Ltd. April, 03.

⁴ АМГгазраас 2009 оны 8-р сард гаргасан мэдээ

өргөн цар хүрээнд явуулснаараа онцлог юм. Судалгааны үр дүнг “Тогтвортой бичил уурхай төсөл”, Бичил Уурхайчдын Холбоо ТББ болон бусад байгууллагууд цаашид үйл ажиллагаагаа төлөвлөх болох хматын ажиллагаагаа бэхжүүлэх зэрэгт ашиглах боломжтой юм.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг хийхэд хамтран ажилласан П. Үржинлхүндэвээр удирдуулсан Швейцарийн Хөгжлийн Агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл, Төв аймгийн Борнуур сумын засаг дарга Н. Мөнхбаатар болон ЗДТГ-ын ажилтан, албан хаагчид, сумын эмнэлэг, цагдаа, татвар, даатгал зэрэг төрийн үйлчилгээний байгууллагын ажилтан, албан хаагчид, ХААН банк, сумын худалдаа үйлчилгээний газрууд, Борнуур Бичил Уурхайчдын Холбооны гишүүд, хувиараа алт олборлогч ХК болон бусад орон нутгийн иргэдэд Хөгжлийн эзэд ТББ-ийн судалгааны багийн өмнөөс талархал илэрхийлье.

Тус судалгааг гардан зохион байгуулж аргачлал хөтөлбөр боловсруулах шатнаас үр дүнг хүлээлгэн өгөх хүртэлх ажилд цаг зав, сэтгэл гарган ажилласан судалгааны багийн ахлах зохицуулагч нийгмийн ухааны магистр Т. Ариунаа, эдийн засагч статистикч Б. Мөнхбаатар болон судалгаанд мэргэжлийн чиглэлийн дагуу баг болон мэдээ, мэдээлэл цуглуулах, компьютерт мэдээлэл оруулах, үр дүнг боловсруулах, нэгтгэх зэрэгт идэвхийлэн оролцож ажилласан бусад мэргэжил нэгт нөхөддөө чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хөгжлийн Эзэд ТББ-ийн Гүйцэтгэх захирал

В. Бэрцэцэг

АГУУЛГА

Нэгдсэн дүгнэлт	11
Бүлэг 1.Танилцуулга	18
1.1. Удиртгал	19
1.2. Судалгааны зорилго, зорилтууд	21
1.3. Судалгааны ажлын зохион байгуулалт, арга зүй	22
1.4. Судалгааны түүвэрлэлт.....	24
1.5. Мэдээллийн шинжилгээ.....	25
1.6. Судалгааны явцад тохиолдсон бэрхшээл.....	26
Бүлэг 2.Борнуур сумын хүн ам зүй, нийгэм-эдийн засаг, ашигт малтмал олборлолтын байдал	27
2.1. Төв аймгийн газар зүй, хүн ам, нийгэм эдийн засгийн талаарх ерөнхий мэдээлэл	28
2.2. Борнуур сумын газар зүйн байрлал, хүн ам зүй, нийгэм эдийн засгийн мэдээлэл	31
2.3. Борнуур сумын ашигт малтмалын нөөц, уул уурхайн салбарын өнөөгийн байдал, бичил уурхайн үүссэн түүхээс	32
Бүлэг 3.Борнуур сумын хувиараа алт олборлогч иргэдийн хүн амын болон нийгэм эдийн засгийн шинж байдал	36
3.1. Хүн ам зүйн шинж байдал	37
3.2. Борнуур сумын хувиараа алт олборлогч иргэдийн гэрлэлтийн байдал.....	39
3.3. Бичиг үсэг тайлагдалт, боловсролын байдал	41
3.4. Ажил эрхлэлтийн байдал	42
3.5. Орон нутгийн харъяалал, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл	44
Бүлэг 4. Хувиараа алт олборлогчдын орлого ба зардал	46
4.1. Алт олборлох шалтгаан.....	47
4.2. Алт олборлолтын хэмжээ, мөнгөн орлого	48
4.3. Алт олборлолтын зардал	51
4.4. Алт борлуулалт ба хуримтлал	53
Бүлэг 5.Алт олборлолт буюу ажил эрхлэлтийн байдал.....	55
5.1. Сүжигтэй уулан дахь алт олборлолтын байдал	56
5.2. Алт олборлох болсон шалтгаан, үр дагавар.....	58
5.3. ХАМО иргэдийн алт олборлох үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа.....	59
5.4. Хувиараа алт олборлогч иргэдийн алт олборлолт хийх эрх зүйн нөхцөл, байдал.....	60
5.5. Хувиараа алт олборлогч нарын ажлын ачаалал, амралт, чөлөөт цаг	61
5.6. Алт олборлогчдын хөдөлмөрийн байрны нөхцөл байдал, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа.....	62
Бүлэг 6. Хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэндийн байдал ба эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж	69
6.1. Хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэндийн байдал	70
6.2. Хувиараа алт олборлогч иргэдийн осол гэмтэлд өртөж буй байдал	73
6.3. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан байдал.....	74
6.4. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж.....	75

Бүлэг 7.Хувиараа алт олборлогч иргэдийн зохион байгуулалт, хамтын ажиллагаа	76
7.1. Хувиараа алт олборлогч иргэдийн дундах нөхөрлөлийн зохион байгуулалт, хамтын ажиллагаа	77
7.2. БУХ ТББ-ын үйл ажиллагаа, үйлчилгээний хүртээмж чанар	83
Бүлэг 8.Дүгнэлт, зөвлөмж.....	89
Дүгнэлтүүд.....	95
Зөвлөмж	95
ХАВСРАЛТУУД	97
Хавсралт 1. Ашигласан хэвлэлийн жагсаалт.....	98
Хавсралт 2. ХАМО иргэдээс авах санал асуулга	99
Хавсралт 3. Ганцаарчилсан ярилцлагын удирдамж	112
Хавсралт 4. Бүлгийн ярилцлагын удирдамж.....	117

ТОВЧИЛСОН ҮГС

АМГ	АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БОЯ	БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ
ГХГЗЗГ	ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР
ДНБ	ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
ДБ	ДЭЛХИЙН БАНК
НХХЯ	НИЙГЭМ ХАМГААЛАЛ ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ
НҮБ	НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА
МХСМТ	МОНГОЛЫН ХОРШООЛЛЫН СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ
МҮОНТ	МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗ
МУИС	МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МХЗ	МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД
ТТБ	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА
ТоБУТ	ТОГТВОРТОЙ БИЧИЛ УУРХАЙ ТӨСӨЛ
УУАА	Уул уурхайн аврах алба
УИХ	Улсын их хурал
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, Эрчим хүчний Яам

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгааны үр дүнд гарч ирсэн гол мэдээллүүд.....	12
Хүснэгт 2. Хүлээгдэж буй үр дүн 1.....	13
Хүснэгт 3. Хүлээгдэж буй үр дүн 2.....	14
Хүснэгт 4. Хүлээгдэж буй үр дүн 3.....	15
Хүснэгт 5. Хүлээгдэж буй үр дүн 4.....	17
Хүснэгт 6. Кейс 1.....	38
Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд.....	39
Хүснэгт 8. Өрхийн ам бүлийн байдал	40
Хүснэгт 9. Хувиараа алт олборлогч иргэдийн ажил эрхлэлтийн байдал	42
Хүснэгт 10. Кейс 2.....	43
Хүснэгт 11. ХАМО нарын ажлын цаг, алт олборлолтын орлого.....	48
Хүснэгт 12. Хувиараа алт олборлогчдын орлогын хэмжээ, хувийн жин	48
Хүснэгт 13. Кейс 3: Борнуур сумын өрх толгойлсон эмэгтэй иргэн Г-ийн 2007 болон 2009 оны өрхийн амжиргааны байдалд хийсэн шинжилгээ	50
Хүснэгт 14. Кейс 4.....	52
Хүснэгт 15. ХАМО иргэдийн ажлын цаг	61
Хүснэгт 16. Кейс 5.....	1
Хүснэгт 17. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх мэдлэг мэдээлэл	62
Хүснэгт 18. Хувиараа алт олборлогчдын хэрэглэдэг ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл	63
Хүснэгт 19. Ажлын байрны хортой хүчин зүйлийн түвшин	65
Хүснэгт 20. ХАМО нарын алт олборлоход хэрэглэдэг багаж хэрэгсэл.....	66
Хүснэгт 21. Алт олборлолтыг сурсан байдал	67
Хүснэгт 22. Кейс 5.....	71
Хүснэгт 23. Хувиараа алт олборлогч нарын өвчлөлийн байдал.....	72
Хүснэгт 24. Хувиараа алт олборлогч нарын дунд нийтлэг тохиолддог гэмтлийн төрлүүд	73
Хүснэгт 25. Кейс 7.....	78
Хүснэгт 26. Кейс 8 – Жендерийн асуудал.....	80
Хүснэгт 27. Кейс 9.....	84

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төв аймгийн газрын зураг	Error! Bookmark not defined.
Зураг 2. Төв аймгийн төсвийн орлогын бүрдэлт.....	29
Зураг 3. Борнуур суманд бичил уурхай үүссэн түүх.....	33
Зураг 4. Хувиараа алт олборлогч иргэдийн нас, хүйсийн байдал.....	37
Зураг 5. ХАМО нарын гэрлэлтийн байдал	40
Зураг 6. Судалгаанд хамрагдсан иргэдийн боловсролын түвшин	41
Зураг 7. Борнуур сумын дундаж хүн ам ба өрхийн тоо /5 жилийн харьцуулалт/	44
Зураг 8. Иргэний бичиг баримттай эсэх, хувийн жин	45
Зураг 9. Алт олборлох болсон шалтгаан	47
Зураг 10. Сарын орлого ба зарлага.....	49
Зураг 11. Ярилцлага өгсөн хүмүүс	1
Зураг 12. Хуримтлал үүсгэж чадахгүй байгаа шалтгаан	53
Зураг 13. Банкны зээлийн төрөл.....	54
Зураг 14. ХАМО иргэдийн үйл ажиллагааны дамжлага.....	56
Зураг 15. Алт олборлох болсон шалтгаан	58
Зураг 16. ХАМО иргэдийн алт олборлосон жил	59
Зураг 17. Хөдөлмөр хамгааллын хувцасны олдоц, хүртээмж	64
Зураг 18. Тэсэлгээтэй холбоотой гардаг хүндрэлүүд.....	67
Зураг 19. 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, цэвэр өсөлтийн харьцуулалт	1
Зураг 20. Хувиараа алт олборлогч иргэдэд илэрдэг өвчлөлийн нийтлэг зовиур.....	71
Зураг 21. Эрүүл мэндийн үйлчилгээ авахад гардаг бэрхшээл	75
Зураг 22. Нөхөрлөлийн давуу талууд.....	78
Зураг 23. Нөхөрлөлд ордоггүй шалтгаан	80
Зураг 24. ТББ-ын үйл ажиллагаа.....	83
Зураг 25. Байгууллагын хөгжлийг тодорхойлох нийгэм сэтгэл зүйн аргачлал	84
Зураг 26. Баримт бичгүүдийн агуулга	85
Зураг 27. ТББ-ын Удирдлага зохион байгуулалт.....	87

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

1 унц – 31.1035 грамм


1 лан – 37.5 грамм

1 цэн – 3.75 грамм

1фун – 0,375 грамм

Байнгын Энэ бүлэгт жилийн 4 улирлын турш байнга ажилладаг, үндсэн ажил эрхлэлт нь хувиараа алт олборлолт болсон хүмүүс ордог.

Түр зуурын Энэ бүлэгт цөөн хоногоор ирээд 1-2 удаа далд уурхайд малталт хийж багахан хүдэр олборлоод буцдаг бүлэг хүмүүс орно



НЭГДСЭН ДҮГНЭЛТ

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Судалгааны багийнхан Төв Аймгийн Борнуур сумын нийгэм эдийн засгийн байдлыг тодорхойлох судалгааг хийхдээ судалгааны үндсэн арга зүй болох холбогдох бичиг баримтуудыг уншиж танилцаж байх явцдаа төслийн зорилго, зорилтууд, гаргахыг эрмэлзэж буй үр дүнгүүдтэй сайтар танилцан дараах товч мэдээлэл, дүгнэлтийг гаргалаа.

ТоБУТөслийн зорилго: ТоБУТ нь Монгол Улсад хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд холбогдох талуудтай хамтран ажиллаж, бичил уурхай эрхлэгчдийн хөдөөгийн тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг оруулах эдийн засгийн дэд салбарын хариуцлагатай гишүүд болгоход хувь нэмэр оруулах болно. Төслийн зорилготой холбоотой дараах үндсэн нөхцөл байдал төсөл хэрэгжүүлж буй орон нутагт байна хэмээн судалгаагаар гарч ирлээ. Үүнд:

Хүснэгт 1. Судалгааны үр дүнд гарч ирсэн гол мэдээллүүд

Үзүүлэлт	Хувь	Тайлбар
Ядуурлын төвшин	36.8%	Оролцооны аргаар авсан судалгааны үр дүн
Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин ⁵	63.5%	Ажиллах хүчийг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан харьцаа
Хувиараа алт олборлогч иргэдийн олборлолт хийх газрын зөвшөөрлийн асуудал	0%	5 талт харилцан ойлголцлын санамж бичиг зурагдсан боловч Түр журмын дагуу лиценз эзэмшигч, Борнуур сумын засаг захиргаа, БУХ ТББ-ын хооронд гурван талт гэрээгээр олборлох газрын зөвшөөрлийг баталгаажуулаагүй байна
Хувиараа алт олборлогч иргэдийн дунд тохиолдож буй осол аваарын байдал	12.5%	Хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрийн осол, аваарыг оролцуулан тооцсон болно.

⁵ 2008 оны Монгол улсын статистикийн эмхэтгэл

Хүлээгдэж буй үр дүн 1: Бичил уурхайн салбарт ил тод, шударга бодлого эрх зүй, зохицуулалтын орчин бүрдүүлж, хэрэгжилтийг эхлүүлсэн байна

Хүснэгт 2.Хүлээгдэж буй үр дүн 1

Үзүүлэлт	Хувь	Тайлбар
Хууль эрх зүйн зохицуулалтын дагуу албан ёсны зөвшөөрөлтэй газар хүдэр олборлолт хийж байгаа хувиараа алт олборлогч иргэдийн эзлэх хувь	0%	5 талт харилцан ойлголцлын санамж бичиг зурагдсан боловч Түр журмын дагуу лиценз эзэмшигч, Борнуур сумын засаг захиргаа, БУХ ТББ-ын хооронд гурван талт гэрээгээр олборлох газрын зөвшөөрлийг баталгаажуулаагүй байна
Нийгмийн даатгалд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн эзлэх хувь	26%	Сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ сард 12500 төгрөг ⁶
Эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, улсаас эрүүл мэндийн үйлчилгээ авч буй хувиараа алт олборлогч иргэдийн эзлэх хувь	65%	Эрүүл мэндийн сайн дурын даатгалын шимтгэлийн хэмжээ сард 500 төгрөг жилд 6000 төгрөг ⁷
ХАОАТ төлдөг хувиараа алт олборлогч иргэдийн эзлэх хувь	10%	Орлогын хэмжээг тодорхойлох боломжгүй иргэдийн ХАОАТ төлөх шимтгэлийн хэмжээ сард 4000 төгрөг ⁸

⁶ Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль

⁷ Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

⁸ Монгол улсын ХАОАТатварын тухай хууль

Хүлээгдэж буй үр дүн 2: Бичил уурхайн бүх түвшинд бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулсан байх

Хүснэгт 3. Хүлээгдэж буй үр дүн 2

Үзүүлэлт	Хувь	Тайлбар
Хувиараа алт олборлогч иргэдийн дундаас тэдний эрх, ашгийг хамгаалах үндэсний байгууллага байх ёстойг дэмжиж байгаа хувиараа алт олборлогч иргэдийн эзлэх хувь	68%	Нийт судалгаанд оролцогчдын дунд эзлэх хувь
БУХ ТББ-ийн зорилго, үйл ажиллагааг дэмжиж ажилладаг хувиараа алт олборлогч иргэдийн эзлэх хувь	85%	Нийт судалгаанд оролцогчдын дунд эзлэх хувь
Улсын болон орон нутгийн хэмжээнд хувиараа алт олборлогч иргэдийн өмнө тулгамдаад байгаа асуудлыг хөндөж шийдүүлсэн байдал	Сайн ⁹	БУХ ТББ Борнуур суманд хүдэр баяжуулах цех байгуулах, олборлолтын газрын асуудал болон бусад олон асуудал дээр хувиараа алт олборлогч нарын эрх ашгийг хамгаалан ажиллаж байгаа гэж оролцогч нар үзэж байна
Хувиараа алт олборлогч иргэдийн байгуулсан бүртгэгдээгүй нөхөрлөлийн тоо	65	-
Бүртгэгдээгүй нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон хувиараа алт олборлогч иргэдийн тоо	196	-

⁹ Оролцооны аргаар цуглуулсан мэдээллүүдэд сайн, дунд, муу гэсэн чанарын хэмжигдэхүүнийг ашиглан тодорхойлов.

Хүлээгдэж буй үр дүн 3: Бичил уурхай эрхлэгчдийн үр ашигтай хариуцлагатай бичил уурхай болон бусад бизнесийн үй ажиллагааг эрхлэх чадвартай болгоход дэмжлэг үзүүлэх

Хүснэгт 4. Хүлээгдэж буй үр дүн 3

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тайлбар	
ХАМО ХК-ний хүдэр баяжуулах цехэд боловсруулагдаж байгаа хүдрийн хэмжээ (өдөрт)	~16 тонн	8 тээрэм ажиллаж байгаа ба нэг тээрмийн хүчин чадал өдөрт 2 тонн болно	
ХАМО ХК-ий хүдэр баяжуулах цехийн нэг тонн хүдрээс ялгаж авч буй алтны хэмжээ	~74%	ХАМО ХК-ний техникийн ажилчдын өгсөн мэдээлэл	
ХАМО ХК-ний хүдэр баяжуулах цехийн өдөрт хийж буй мөнгөн орлогын дүн	~2,160,000 төг	1 тн хүдрийг боловсруулах үйлчилгээний хөлс 135,000 төгрөг ба өдөрт ойролцоогоор 16 тн хүдэр боловсруулдаг.	
Үзүүлэлт	Өдөр	Долоо хоног	Сар
Хувиараа алт олборлогч иргэдийн орлоготой ажилладаг хоногийн тоо	-	3	15
Хувиараа алт олборлогч иргэдийн олборлож буй алтны дундаж хэмжээ (өдөр, долоо хоног, сараар)	0,6 гр	1,8 гр	9гр
Хувиараа алт олборлогч иргэдийн орлогын дундаж хэмжээ (өдөр, долоо хоног, сараар)	24000 төг	43200төг	360000 төг
Борнуур сумын төсвийн болон хувийн хэвшлийн	-	-	237000төг ¹⁰

¹⁰ Төв аймгийн статистикийн хэлтсийн гаргасан Эдийн засаг, нийгмийн байдлын тухай мэдээ 2009 оны 10-р сар

Төв аймгийн Борнуур сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа

худалдаа, үйлчилгээний байгууллагуудад ажилладаг иргэдийн сарын дундаж цалингийн хэмжээ			
---	--	--	--

Хүлээгдэж буй үр дүн 4: Бичил Уурхай эрхлэгчид ба бусад нөөц ашиглагчдын байгаль экологи, нийгмийн асуудалд хариуцлагатай хандаж, гарч буй зөрчлүүдийг шийдэж чаддаг чадвартай болох

Хүснэгт 5. Хүлээгдэж буй үр дүн 4

Үзүүлэлт	Хувь	Тайлбар
Хувиараа алт олборлогч иргэдийн дунд гарч байгаа гэмт хэрэг зөрчлийн тоо	1.9%	Сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн гаргасан мэдээнээс
Хувиараа алт олборлох үйл ажиллагаатай холбоотой зөрчил маргаанууд	Олон ¹¹	Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаас олж авсан мэдээлэл (уурхайн ам, хөдөлмөр хуваарилалт, ашиг хуваарилалтын байдал, тоног төхөөрөмж түрээс, ашиглалт гэх мэт)
Байгаль орчин, хүний биед сөрөг нөлөө бүхий химийн хорт бодис хэрэглэн алт боловсруулж байгаа байдал (Hg)	Үгүй	2008 оны 2-р сард ТОБУТөслийн санхүүжилтээр мөнгөн усгүй хүдэр боловсруулах цех ашиглалтанд оруулснаас хойш ил, далд хэлбэрээр ахуйн болон үйлдвэрлэлийн орчинд мөнгөн ус хэрэглэн алт бариулах үйл ажиллагаа бүрэн зогссон.
Цехийн хаягдлыг дахин боловсруулж, ашиглаж байгаа байдал	Үгүй	Шламыг одоогийн байдлаар ашиглаж эхлээгүй байна.
Хувиараа алт олборлох үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл	Бага	Хувиараа алт олоборлогч иргэд түлшний зориулалтаар ургаа мод огтлох, ахуйн хог хаягдлаар орчноо бохирдуулах үзэгдэл ажиглагдлаа.

¹¹ Оролцооны аргаар цуглуулсан мэдээллүүдэд олон, дунд, цөөн гэсэн чанарын хэмжигдэхүүнийг ашиглан тодорхойлов.



БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА

1.1. УДИРТГАЛ

Алтны эрэлт хэрэгцээ тасралтгүй өсөж байгаатай уялдан түүний үнэ дэлхийн зах зээл дээр тасралтгүй нэмэгдсээр байгаа бөгөөд алт олборлолтоороо өмнөд африкийн орнууд, АНУ, Канад, Орос, Хятад зэрэг орнууд тэргүүлсээр байна. Монгол Улсын хувьд алт олборлох үйл ажиллагаанд гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор Монгол Улсын засгийн газрын 1990 оноос “Алт-1”, 2000 оноос “Алт -2” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн уул уурхайн үсрэнгүй хөгжлийн үндэс суурь болсон байна.

Ингэснээр өнгөрсөн 17 жилийн дотор Монгол улсын алтны үйлдвэрлэл асар хурдацтай хөгжсөн бөгөөд бараг 30 дахин нэмэгдсэн байна. Гэхдээ Монгол Улсын Их Хурлаас 2006 онд Ашигт Малтмалын тухай хуульд оруулсан томоохон өөрчлөлтүүд, Алт, Зэсийн үнийн гэнэтийн өсөлтийн татварын тухай хууль батлагдсан нь нийт уул уурхайн салбар ялангуяа алт үйлдвэрлэлийн салбарт сөргөөр нөлөөлсөн. Үүний улмаас 2005 онд Монгол улс 24.1 тонн алт олборлодог байсан бол 2008 онд 2,1%-иар буюу 15,1 тонн болтлоо буурсан байна.

Ашигт малтмалын газраас ¹² гаргасан мэдээллээс харахад манай улсын 18 аймгийн 100 гаруй цэгт 54000 гаруй хувиараа ашигт малтмал олборлогч нар үйл ажиллагаагаа явуулж байгаа талаар өгүүлсэн байна. Нийт хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн 90% нь алтны үндсэн ба шороон ордонд ажиллаж байна. Гэхдээ энэ төрлийн үйл ажиллагааг хэдэн хүн эрхэлж байгаа талаар тодорхой мэдээлэл, судалгаа байдаггүй нь тэдний эрхэлж байгаа үйл ажиллагааны онцлог болох алтны гарц, нөөц, түүнийг дагасан шилжилт хөдөлгөөний урсгалтай шууд холбоотой юм.

2005 оноос Швейцарийн Хөгжлийн Агентлаг, АМГ-тай хамтран ТоБУТ-ийг Монгол улсад хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэхэд холбогдох талуудтай хамтран ажиллаж, бичил уурхай эрхлэгчдийн хөдөөгийн тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг дээшлүүлэх бичил уурхайчдыг

¹² АМГ-гаас 2009 оны 8-р сард гаргасан мэдээ

эдийн засгийн дэд салбарын хариуцлагатай гишүүд болгоход хувь нэмэр оруулах зорилгоор хэрэгжүүлж байна.

ТоБУТ-ийн саналаар Төв аймгийн Борнуур суманд хувиараа алт олборлогч иргэдийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэх суурь судалгааг явууллаа.

1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

1.2.1. Судалгааны зорилго

Борнуур сумын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг тодорхойлох, тус суманд хувиараа алт олборлож буй иргэдийн үйл ажиллагаа, тэдний орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр, нөлөөллийг тодорхойлох.

1.2.2. Судалгааны зорилтууд

1. Борнуур суманд хувиараа алт олборлож буй иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг судлах
2. Хувиараа алт олборлож буй иргэдийн алт олборлолтын хувь хэмжээ, борлуулалтын зах зээл, үнэ ханш, орлого ба зарлагыг тодорхойлох
3. Хувиараа алт олборлогч иргэдийн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодорхойлох
4. Хувиараа алт олборлогч иргэд болон сумын оршин суугчдын амьжиргааны түвшинг харьцуулан тодорхойлох
5. Хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны байдалд дүн шинжилгээ хийх
6. Хувиараа алт олборлогч иргэдийн харилцаа холбоо, хамтын ажиллагаа, бусадтай эвлэлдэн нэгдэх, бүтэц зохион байгуулалтанд орж буй хэлбэрийг тодорхойлох,
7. Хувиараа алт олборлогч иргэдийн үйл ажиллагаа, байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн талаархи олон нийтийн ойлголт хандлага

1.3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГА ЗҮЙ

Судалгааг ТоБУТөслийн саналаар Хөгжлийн Эзэд ТББ-ын судлаач нараас бүрдсэн судалгааны баг арга, аргачлал боловсруулах, түүвэр, түүвэрлэлт хийх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих үйл ажиллагааг зохион байгуулан 2009 оны 12-р сарын 7-ноос 2010 оны 01 сарын 11-ны хооронд явуулав. Судалгааны мэдээллийг компьютерт оруулах үр дүнгийн хүснэгтийг боловсруулах, тайлан бичих ажилд ТоБУТ-ийн үйл ажиллагааны багийн ажилтнуудаас санал зөвлөгөө авч хамтран ажиллалаа.

Судалгааны зорилго, зорилтуудад хүрэхийн тулд тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан хэрэглэсэн. Үүнд:

- Ажиглалт
- Харьцуулалт
- Төсөөллийн зэрэглэл
- Орон нутагтай танилцах аялал
- Зураглал
- Фокус бүлгийн хэлэлцүүлэг
- Гүнзгийрүүлсэн ярилцлага
- Кейс судлал
- Улирлын хуанли хөтлөлт

Шаардлагатай мэдээ мэдээллийг нийгмийн судалгааны тоон ба чанарын аргыг ашиглан цуглуулсан. үүнд Тоон судалгаанд холбогдох статистик тоо баримт, бусад судалгааны үр дүн асуумжийг ашиглав.

Асуумжийн бүтэц:

- Ерөнхий мэдээлэл (1-хэсэг)
- Өрхийн амьжиргааны байдал (2-хэсэг)

- Орон нутгийн харъяалал, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл (3-хэсэг)
- Алт олборлолт буюу ажил эрхлэлтийн байдал(4-хэсэг)
- Хувиараа алт олборлогч иргэдийн орлого зарлагын байдал (5-хэсэг)
- Хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэндийн байдал ба эрүүл мэндийн үйлчилгээ (6-хэсэг)
- Нийгмийн үйлчилгээ ба нийгмийн даатгал (7-хэсэг)
- Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн зохион байгуулалт, хамтын ажиллагаа (8-хэсэг) гэсэн хэсэг бүхий асуултаас бүрдсэн.

Асуултын 90 гаруй хувь нь олон сонголт бүхий хариулттай байлаа.

Ярилцлаганд хамрагдсан бүлэг:

- Сумын удирдлага
- Нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, хэлтсүүд
- Сумын хүн эмнэлэг
- Сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгч
- Байгаль орчны байцаагч
- ХААН банк
- Шатахуун түгээх станц
- Худалдаа, үйлчилгээний газрууд
- Хувиараа алт олборлогч иргэд
- Бусад

1.4. СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

Судалгааны эх олонлогт тухайн үед алт олборлож байсан 18 ба түүнээс дээш настай Монгол улсын иргэдийг хамруулан, энгийн санамсаргүй түүврийн зарчмаар судалгаанд оролцогчийг сонголоо.

Хувиараа алт олборлогсдын бодит тоог улирлын хэлбэлзэл, онцлог зэргээс шалтгаалан гаргахад хүндрэлтэй байдгийг харгалзан 95 хувийн түвшинд 5.0 хувийн алдааны магадлалтайгаар байхаар тооцон Борнуур сумын Сүжигтэй ууланд алт олборлогч иргэд болон хувиараа алт олборлогч компаний үйлчлүүлэгч 100 гаруй хувиараа алт олборлогчдийг түүвэрлэн судлахад тохиромжтой гэж үзлээ.

Анкетын судалгаанд хувиараа алт олборлож буй 100 иргэнийг сонгосон ба 93% нь Борнуур сумын иргэн, 7% Зүүнхараа, Баянхонгор зэрэг бусад аймгуудаас ирсэн хүмүүс байлаа.

1.5. МЭДЭЭЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Тоон судалгааны мэдээллийг оруулж, үр дүнгийн шинжилгээ хийн, мэдээлэл боловсруулахад **SPSS –17** программ хангамжийг ашиглав. Чанарын судалгааны мэдээлэл боловсруулалтад Simple text analyse болон үр дүнгийн агуулгын дагуу бүлэглэн матриц үүсгэн, нэгтгэж дүгнэлт хийв.

1.6. СУДАЛГААНЫ ЯВЦАД ТОХИОЛДСОН БЭРХШЭЭЛ

- Хувиараа алт олборлогч иргэдийн дунд өрхийн орлого зарлагаа урьд нь тооцож үзээгүйн улмаас орлого зарлагаа тодорхойлоход нилээд цаг хугацаа зарцуулж байсан.
- Судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь эрэгтэйчүүд байсан нь өрхийн нарийн тооцоо, зарцуулалтын талаарх мэдээлэл гаргаж өгөхдөө тааруу байв.
- Судалгаа авах үе нь шинэ жилийн баярын өмнөхөн байсан болон цаг агаар маш хүйтэн байсан учраас хувиараа алт олборлогч иргэд маань тэр бүр ууланд олноороо ажиллаж байсангүй.
- Өрхийн орлого, зарлага зэрэг нь тухайн өрхийн хувийн чанартай асуулга байсан байсан учраас зарим судалгаанд оролцогчид мэдээлэл өгөхдөө эмзэглэх, буруугаар ойлгох тохиолдол гарч байсан.
- хувиараа алт олборлогч иргэд мэдээлэл өгөхдөө хэн нэгнээс айсан болгоомжилсон маягтай нээлттэй биш байх хандлага ажиглагдаж байлаа.

БҮЛЭГ 2

БОРНУУР СУМЫН ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ, АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТЫН БАЙДАЛ




2008 оны байдлаар Монгол Улсад ашигт малтмалын хайгуул, ашиглалтын хүчин төгөлдөр 4644 тусгай зөвшөөрөл байна. 4644 лицензийн 22,8% буюу 1060 нь ашиглалтын үлдсэн 3584 хайгуулын лиценз байна.

Нийт 44,81 сая га талбай лицензэд олгогдсон байгаа нь Монгол улсын нийт газар нутгийн 28 орчим хувьтай тэнцэх юм. 1060 ашиглалтын лицензийн 462 буюу 44% алтны лиценз байна. Хамгийн их лицензтэй аймгаар Төв, Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь шалгарч байгаа бол хамгийн цөөн лицензтэй аймагт Говьсүмэр, Орхон хоёр орно.

Төв аймгийн хэмжээнд ашиглалтын 536, хайгуулын 174 лиценз олгогдсон байна. Лицензийн талбайг гаргавал ашиглалтын лицензээр 1230,714 га, хайгуулын лицензээр 44,140 га газар олгогдсон байна. Алт олборлолт хамгийн ихээр явагдаж байгаа аймгуудад Төв, Сэлэнгэ, Баянхонгор, Дархан Уул аймгууд орж байна. Эдгээр аймгуудад хамгийн олон тооны алтны ашиглалтын лиценз олгогдсон байна.

Төв аймгийн 2008 оны төсвийн орлогын 52,8%-ийг татвар төлбөр, хураамжаас бүрдүүлсэн бөгөөд энэхүү татвар хураамжийн орлогын 21,5% нь ашигт малтмалын нөөцийн төлбөр, 10,4% нь ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахтай холбоотой төлбөр хураамжаас бүрдсэн байна.

Зураг 2. Төв аймгийн төсвийн орлогын бүрдэлт



2009 оны 11-р сарын байдлаар Төв аймгийн хувьд нэг хүнд ногдох төсвийн дундаж зарлага нь 243,980 төг, төсвийн дундаж орлого нь 69,000 байна. Харин төсвийн зарлагын бүтцэд ангилалт хийж үзвэл нийт төсвийн 57.27% нь ажилчдын цалин хөлс, төрийн байгууллагын үйл ажиллагааны зардал болох түрээс, бичиг хэрэг, холбоо харилцаа, томилолт, ном хэвлэл, хувцасны хангалт зэрэг бараа үйлчилгээнд 29.93% зарцуулагдсан байсан ба үлдсэн 12,8% нь хөрөнгө оруулалт, нийгмийн даатгалын шимтгэл, оюутны тэтгэлэг, нэг удаагийн бусад тэтгэлэг, хот тохижилт зэрэг үйл ажиллагаанд зарцуулагдсан байна.

Аймгийн хэмжээнд 32 ерөнхий боловсролын сургууль байдаг дунджаар 15,000 хүүхэд суралцдаг. Эрүүл мэндийн үйлчилгээний хувьд нэг эрүүл мэндийн салбарын ажилтанд ногдох хүний тоо 394 буюу хамгийн өндөр ачаалалтай ажилладаг нь харагдаж байлаа.

Тус аймагт 2005 онд 647 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байсан бол 2008 оны 12 сарын байдлаар энэ тоо 721 болж өссөн байлаа¹³.

¹³ 2008 оны Монгол улсын статистикийн эмхэтгэл

2.2. БОРНУУР СУМЫН ГАЗАР ЗҮЙН БАЙРЛАЛ, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭЛЭЛ

Борнуур сум нь Төв аймгийн хойд хэсэгт оршдог ба хойд хэсгээрээ Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал, баруун талаараа Төв аймгийн Жаргалант, Баянцогт, урд талаараа Баянчандмань сумдуудтай хил залгаа оршдог. Тус сум нь нийслэл Улаанбаатар хотоос 100км, Төв аймгийн төв Зуунмод хотоос баруун хойш 150 км зайд оршдог. Тус сум нь 114 мянган хавтгай дөрвөлжин талбай эзэлдэг. Борнуур сум нь далайн түвшнөөс дээш 900-1,500 метрийн өндөрт өргөдсөн ба хамгийн өндөр цэг нь Гунан голын ай сав орчимд 1,728 метр өндөрт өргөгджээ. Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд жилийн дундаж хур тунадасны хэмжээ 265мм, өвөлдөө дунджаар -35С, зуны цагт дунджаар +25⁰С-аас +30⁰С градус дулаан байдаг. Монгол орны бусад сумдуудтай харьцуулахад хүн амын төвлөрөл харьцангуй ихтэй сумд тооцогддог бөгөөд нэг квадрат километр газарт 4 хүн ногддог.

Төв аймгийн Борнуур сум нь нийт 1,315 өрхийн 4,677 хүн амтай бөгөөд нэг өрхийн дундаж гишүүдийн тоо нь 4.8 хүн байна. Засаг захиргааны нэгжийн хувьд Борнуур сум нь Өгөөмөр, Нарт, Бичигт, Мандал гэсэн 4 багтай. Өгөөмөр баг нь 414 өрхийн 1,402, Нарт баг нь 265 өрхийн 986, Бичигт баг нь 342 өрхийн 1,220, Мандал баг нь 294 өрхийн 1,069 хүн амтай. Тус сумын нийт хүн амын 64.8%-ийг хөдөлмөрийн насны иргэд эзэлж байна. Нийт хөдөлмөрийн насны иргэдийн 48.9% нь эмэгтэйчүүд, үлдсэн 51.1% нь эрэгтэйчүүд байна.

Нийт хүн амын 27,4% буюу 1,282 нь 0-14 насны хүүхдүүд, 68,2% буюу 3,192 нь 15-64 насныхан, 4,34% буюу 203 нь 65-аас дээш насны хүмүүс байгаа бөгөөд хүн ам зүйн ачаалал нь 46,5% байна. Үүнээс ажилгүй иргэдийн тоо 945 байна. Тус суманд 100 хүүхдийн цэцэрлэг, 987 хүүхэд суралцдаг ерөнхий боловсролын сургууль, 75 хүүхдийн дотуур байр, номын сан, соёлын төв байдаг.

2.3. БОРНУУР СУМЫН АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БИЧИЛ УУРХАЙН ҮҮССЭН ТҮҮХЭЭС

Газар зүйн байрлалын хувьд хангай, хээр хосолсон үржил шимтэй хөрс бүхий, цаг агаарын тааламжтай бүс нутагт байрладаг бөгөөд ой мод, ус болон алтны орд, төмрийн хүдэр, вольфрам болон чанар сайтай элс, хайрга зэрэг эрдсээр баялаг тогтоцтой юм. Тухайлбал Төв аймаг нь чулуун нүүрс төмрийн хүдэр, хар тугалга, гянт болд, усан ба утаат болор, жонш, оюу, номин, гялтгануур мана, цагаан тугалга зэрэг ашигт малтмалтай.

Хамгийн их хайгуулын болон ашиглалтын лицензтэй аймгийн тоонд Төв аймаг нь зүй ёсоор ордог юм. Тодруулбал, Төв аймгийн хэмжээнд ашиглалтын 536, хайгуулын 174 лиценз олгогдсон байна. Лицензийн талбайг гаргавал ашиглалтын лицензээр 1230,714 га, хайгуулын лицензээр 44,140 га газар олгогдсон байна. Тус аймгийн хамгийн том лиценз буюу 600 га талбайг Канадын хөрөнгө оруулалттай Сентера Гоулд компани эзэмшдэг. Уг компани нь 1997 оноос хойш тус аймгийн нутаг дэвсгэрт алтны олборлолт явуулсаар ирсэн. Мөн тус сумын Харгант хэмээх үндсэн ордод Гүнбилэг компани ашиглалтын лиценз эзэмшдэг ба алт олборлох үйл ажиллагаа явуулдаг.


Социализмын үед уг сумыг Монгол Улсын газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гол бүс нутаг болгон хөгжүүлж байсан түүхтэй. Социалист системийн уналт, жил дараалан тохиолдсон ган зуд зэрэг байгалийн гамшгуудаас шалтгаалан малчид, тариаланчид өөрсдийн эрхэлж байсан хөдөө аж ахуйн бизнес, үйл ажиллагаагаа эрхлэх боломжгүй болсон. Тиймээс орон нутгийн иргэд орлого олох, амьжиргаагаа залгуулах өөр өөр боломжуудыг хайн зарим нь хот суурин газар луу нүүж, үлдсэн зарим хэсэг нь хувиараа алт олборлон амьжиргаагаа залгуулах болсон байна. Борнуур суманд хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа бий болох шалтгааныг доорхи байдлаар бүдүүвчлэн¹⁴ харууллаа.

¹⁴ 03 WB Overview of artisanal mining in Mongolia

Алт олборлох үйл ажиллагаа нь бий болсноороо нийгэмд эерэг, сөрөг олон үр дагавруудыг бий болгосны нэг үндсэн ордтой холбоотой мөнгөн усны хэрэглээ байсан юм. 1995-2005 оны хооронд хийгдэж байсан судалгааны материалуудыг судалж үзэхэд тухайн 400 гаруй алт олборлогчид Борнуур суманд алт олборлож байсан бөгөөд нэг хувиараа алт олборлогч иргэн жилд дунджаар 400 грамм мөнгөн ус хэрэглэж 223,8 грамм алт авдаг байсан тухай мэдээлэл байна. Үүнээс үзвэл Борнуур сумын мөнгөн усны хэрэглээ асар өндөр байсан нь тодорхой байна. юм. Мөн нийт хэрэглэгдэж байсан мөнгөн усны 85 гаруй хувь нь хятадаас импортоор орж ирж байсан.

Үлдсэн хувь бусад сувгаар тухайлбал Бороо голд алдсан мөнгөн шүүж авах замаар алт олборлогч нарын гарт орж ирэн ашиглагдаж байжээ.

Зураг 1. Борнуур суманд бичил уурхай үүссэн түүх



Энэ мэтээр алтны үндсэн ордод химийн хорт бодис ялангуяа мөнгөн усыг асар их хэмжээгээр хэрэглэж, хадгалалт тээвэрлэлтийн горимыг алдаж, ахуйн нөхцөлд алт бариулж, барьсан алтаа ууршуулах замаар цэвэршүүлж байсан учир 2007 онд Ерөнхий сайдын үүрэг болгосны дагуу Улсын мэргэжлийн хяналтын газраас химийн хорт болон аюултай бодисын тухай

хуулийн хэрэгжилтэнд хийсэн үзлэг шалгалтаар улсын хэмжээнд нийт 147 тээрмийг хурааж устгасан.

Энэ шийдвэр нь нэг талдаа хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд тулгамдаад байсан нэгэн хэцүү асуудлыг шийдэхэд дөхөм болсон хэдий ч нөгөө талдаа маш олон хүний амьжиргааны орлогын эх үүсвэрийг нь үгүй хийж, иргэдийн ахуй амьдрал амьжиргаанд хүнд цохилт болсон. Иймээс иргэд өөрсдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, ажлын байр, орлогоо хууль эрх зүйн хүрээнд баталгаажуулах зорилгоор Бичил Уурхайчдын Холбоо төрийн бус байгууллагыг 2007 онд өөрсдийн санаачлагаар байгуулжээ.

Холбооны үйл ажиллагаа мөнгөн уснаас татгалзах уриалгаар эхэлж, Борнуур мөнгөн усгүй амьдрал сэдэвт зөвлөгөөнийг Борнуурт зохион байгуулсан. Зөвлөгөөний үр дүнд Борнуур суманд мөнгөн усгүй технологиор хүдэр баяжуулах цехийн төсөл хэлэлцэгдэж дэмжигдсэн байна. Энэ төслийг БУХ ТББ-ийн үүсэл санаачлагаар байгуулагдсан ХАМО компани амжилттай хэрэгжүүлэн хүдэр баяжуулах үйлчилгээг 2008-аас үзүүлж байна.

Гэхдээ энэхүү үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах хууль эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байгаа нь ажиглалт, ярилцлагын явцад харагдаж байлаа. Бичил уурхайг хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд хөгжүүлж чадсан тохиолдолд олон тооны ажлын байр бий болох, ажилгүйдэл ядуурал буурах, хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах боломж асар их байгаа нь харагдсан. Өнгөрсөн хугацаанд засгийн газар бичил уурхайтай холбоотой хэд хэдэн чухал эрх зүйн акт, журмуудыг батлан хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Хувиараа алт олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай Засгийн газрын 28-р тогтоол
2. Монгол улсын засгийн газрын Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр
3. Монгол улсын засгийн газрын хувиараа ашигт малтмал олборлогч байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам, 72-р тогтоол

Эдгээр тогтоол, журмуудыг гарган мөрдүүлснээр хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа Бичил уурхайн хэлбэрт шилжих, бичил уурхайн олборлолт, техник технологийн тухай асуудлууд шийдэгдэж эхэлсэн байна.

Ингэснээр хувиараа алт олборлогч иргэдийн хамтын ажиллагааны зохион байгуулалт, орлогын эх үүсвэр болон ажлын байрны баталгаажилт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, нийгмийн бусад харилцааг зохицуулахад нааштай өөрчлөлтүүд гарсаар байна.

БҮЛЭГ 3.


БОРНУУР СУМЫН ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ХҮН АМЫН БОЛОН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖ БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан алт олборлогч иргэдийн нас хүйсийн бүтэц, гэрлэлтийн байдал, боловсролын түвшин, шилжилт хөдөлгөөний талаар энэ бүлэгт харуулна.

3.1 ХҮН АМ ЗҮЙН ШИНЖ БАЙДАЛ

Борнуур суманд алт олборлож байгаа алт олборлогч иргэдийн 68%-ийг эрэгтэйчүүд, 32%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Хүйсийн харьцаа 2.1 буюу нэг эмэгтэй тутамд 2.1 эрэгтэй ноогдож байна. Энэ нь үндсэн ордод алт олборлох ажил харьцангуй хүнд нөхцөлтэй эрэгтэйчүүдийн оролцоог ихээр шаарддагтай холбоотой юм.

Зураг 2. Хувиараа алт олборлогч иргэдийн нас, хүйсийн байдал



Судалгааны явцад 18-25 насны эрэгтэйчүүд хувиараа алт олборлох үйл ажиллагаанд нилээд идэвхтэй оролцож байгаа нь харагдаж байлаа. Борнуур сумын залуучууд ерөнхий боловсролын сургууль төгссөнийхөө дараа үргэлжлүүлэн их, дээд сургууль, коллежуудад элсэн орж чаддаггүй, орон нутагт ажлын байр дутмаг зэрэг шалтгааны улмаас залуучуудын дунд алт олборлож мөнгө олох явдал элбэгшиж байна. Мөн нөхөрлөлийн ахлагч нар ч гэсэн 18-25 насны эрүүл чийрэг, хурдан гавшгай хөдөлгөөнтэй залуучуудыг гишүүнээр авах сонирхол ихтэй байдаг байна. Харин 18-25 насны эмэгтэйчүүдийн хувьд уулын ажилд оролцохоосоо илүү хоол цай хийх, юм угаах, цэвэрлэх зэрэг арын ажилд илүү тусалдаг. Харин уулын ажил буюу хүдэр олборлох ажлыг 43-50 насны ганц бие өрх толгойлсон эмэгтэйчүүд нилээд түлхүү хийж байгаа нь ажиглагдлаа.

Кейс -1

Хүснэгт 6. Кейс 1

Хүйтэн, ус чийгтэй, харанхуй, гүнзгий нүхэнд хатуу хад, чулууг гар багажаар бутлаж, өргөж гаргана гэдэг эмэгтэй хүнд байтугай эрэгтэй хүний хувьд маш хэцүү ажил юм. Орон нутагт ажлын байр хомс байдаг ба байсан ч нас хүйс, мэргэжил боловсрол зааж сонгон шалгаруулалт нэрэн доор танил талаа ажилд авдаг нийтлэг асуудал байдаг учир ажилд орж чаддаггүй. Газар тариалан, МАА болон бусад жижиг бизнес эрхлэхийг хүсвч хөрөнгө мөнгөний дутагдалтайгаас болж эрхэлж чадахгүй байна. Тиймээс амьдралын эрхээр л үр хүүхэд ар гэрээ тэжээхийн тулд ууланд даарч хөрөн, хүмүүст хөөгдөж, туугдан ажиллаж байна.

Иргэн Л, 41 настай

3.2. БОРНУУР СУМЫН ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ


Судалгаанд оролцсон хувиараа алт олборлогч иргэдийн гэрлэлтийн байдал, гэр бүлийн бүтцэд хийсэн ажиглалт судалгаанаас харахад нийт оролцогчдын 78% нь баталгаатай гэр бүлтэйгээ амьдардаг, 12% нь ганц бие, 8% нь бэлэвсэн, 2% нь гэр бүлээсээ салсан хүмүүс байв.

Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн хувийн жин, сонгосон үзүүлэлтүүд

Сонгогдсон үзүүлэлт	Сүжигтэй орд
Хүйс	
Эрэгтэй	68%
Эмэгтэй	32%
Насны бүлэг	
18-25	30%
26-42	30%
43-50	24%
50+	16%
Гэрлэлтийн байдал	
Гац бие	12%
Гэрлэсэн	78%
Салсан	2%
Бэлэвсэн	8%
Тухайн орон нутагт бүртгэлтэй эсэх	
Бүртгэлтэй	93%
Бүртгэлгүй	7%
Бүгд	100%

Судалгаанд 18-аас дээш насны хувиараа алт олборлогч иргэдийг хамруулсан бөгөөд 50 ба түүнээс дээш насны хүмүүс хамгийн бага хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь гэр бүлтэй хүмүүс байсан.

Зураг 3. ХАМО нарын гэрлэлтийн байдал



Эндээс харахад хувиараа алт олборлох үйл ажиллагаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хамтын ажиллагааны үр дүн байж болох юм гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Учир нь эрэгтэйчүүд уулын ажлаа хийж, алт олборлоход анхааран ажиллах, харин эмэгтэйчүүд хоол ундаа бэлдэх, нөхөр, үр хүүхдийнхээ хувцсыг угааж, гэр орноо цэвэрлэх, өрхийн орлогоо тооцон зардлаа хуваарилах зэргээр өрхийн төсвөө барьдаг болох нь ажиглагдаж байлаа. Мөн энэхүү судалгаанаас гарсан мэдээлэл нь хөдөөд хотыг бодвол гэр бүл салалтын хувь хэмжээ харьцангуй бага байдаг гэсэн бусад байгууллагуудын хийсэн дүгнэлтүүдтэй нийцэж байна.

Хүснэгт 8. Өрхийн ам бүлийн байдал


Ам бүлийн тоо	Эзлэх хувь
1 - 3	28%
4 - 6	52%
7- оос дээш	20%
Нийт	100%

Хувиараа алт олборлох үйл ажиллагаа тогтмол эрхэлж байгаа 100 хүний ард 200 -700 гаруй /нэг хүний ард дунджаар 4.8 / гэр бүлийн гишүүд болох эхнэр, хүүхэд, өндөр настай эцэг эх, өвөө эмээ, хөдөлмөрийн чадваргүй ах эгч нар нь байгаа болох нь харагдаж байна. Үүнээс үзэхэд нийгэм, хууль эрх зүйн хүрээнд бүрэн утгаараа хүлээн зөвшөөрөгдөхгүй “хууль бус” хэмээн нэрлэгдэж байгаа хэдий ч хувиараа ашигт малтмал олборлогчид маань гэр бүлийнхээ өмнө, цаашилбал орон нутгийн, аймаг улсын хэмжээнд төр, засгийн газрын хүлээх ёстой үүрэг, хариуцлагыг үүрэлцэж, орон нутгийнхаа эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмрийг оруулж байна.

3.3 БИЧИГ ҮСЭГ ТАЙЛАГДАЛТ, БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан иргэдийн 98% нь бичиг үсэг мэддэг, 2% нь бичиг үсэг мэддэггүй гэж хариулсан байна¹⁵. Ерөнхий боловсролын сургууль төгссөнийхөө дараа үргэлжлүүлэн их, дээд сургууль, коллежуудад элсэн орж чадаагүй орон нутагт ажлын байр дутмаг байгаа зэрэг шалтгааны улмаас залуучуудын дунд алт олборлож мөнгө олох явдал элбэгшиж байна.

Зураг 4. Судалгаанд хамрагдсан иргэдийн боловсролын түвшин



¹⁵ Бичиг үсэг тайлагдалтын улсын дундаж 97,6% (2008 оны Монгол улсын Статистикийн эмхэтгэл)

3.4.АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Судалгаанд оролцогчдын давхар ажил эрхлэлтийн байдлыг судалж үзэхэд ихэнх хувь нь МАА, газар тариалангийн үйл ажиллагааг алт олборлох үйл ажиллагаатай давхар эрхлэж байлаа.

Хүснэгт 9.Хувиараа алт олборлогч иргэдийн ажил эрхлэлтийн байдал

Сонгосон үзүүлэлтүүд	Сүжигтэй орд
Давхар ажил эрхлэлт - Ажил эрхэлдэг - Ажил эрхэлдэггүй	32% 68%
Мэргэжлийн чиглэл - ХАА - Боловсрол - Техник мэргэжлийн - Эрүүл мэндийн - Эдийн засгийн - Худалдаа үйлчилгээний - Хууль хяналт хүчний байгууллага - Мэргэжилгүй	27% 2% 16% 0 3% 11% 2% 39%
Хувиараа ашигт малтмал эрхэлж буй хугацаа 1 жил 1-5 жил 5-10 10 түүнээс дээш	5% 31% 43% 21%
Нийт	100%
Хувиараа ашигт малтмал олборлож байгаа дундаж хугацаа	6,9 жил

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 43% нь хувиараа алт олборлох ажлыг 5-10 жилийн хугацаанд эрхэлж байгаа бөгөөд энэ ажлыг эрхэлсэн дундаж хугацаа нь 6,9 жил байна. Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай болон өрх толгойлсон нялх хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хувьд ажил хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшний байдал харьцангуй бага байлаа. Эдгээр хүмүүс ууланд “аргал түүж” буюу нөхөрлөлүүдийн олборлох явцдаа орхисон хаягдал хүдрүүдийг түүн, баяжуулах замаар орлого олж байна.

Харин залуу, эрүүл, биеийн хүчний ажил хийж чадахуйц эрэгтэй хүмүүсийн хувьд бичил уурхайчдын бүртгэгдээгүй нөхөрлөлд гишүүнээр элсэн ууланд гарч алт олборлож амьжиргаагаа залгуулж байна.

Мөн бага цалинтай болон улирлын чанартай ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүс, төсвийн зарим ажилчид, газар тариалан эрхлэгчид, малчид орлогоо нэмэгдүүлэх зорилгоор хувиараа алт олборлодог болох нь ярилцлагуудын үед тодорхой харагдаж байлаа.

Кейс -2

Хүснэгт 10. Кейс 2

Би сумын сургуульд багшилдаг. Эхнэр 5-18 насны 4 хүүхдийнхээ хамт амьдардаг. Эхнэр маань сумын нэгэн дэлгүүрт худалдагчаар ажилладаг. Хэдийгээр ажилгүй, өрх толгойлон амьдарч байгаа боломжгүй амьдралтай хүмүүсийг бодвол хоёр зэрэг ажил хөдөлмөр эрхлэн цалин хөлс авдаг хэдий ч гэр бүлийнхээ хэрэгцээг хангахуйц хэмжээний орлого олж чаддаггүй. Тиймээс найз нөхөд, хамаатан садангуудтайгаа нийлэн ууланд гарч алт олборлодог. Ялангуяа намар хичээлийн шинэ жил эхлэхийн өмнө, өвөл шинэ жил, цагаан сарын өмнө алт ухахаас өөр аргагүйд хүрдэг.


Ярилцагч багш Б, 35 настай

3.5. ОРОН НУТГИЙН ХАРЪЯАЛАЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хүн амын шилжих хөдөлгөөн Монгол улсын үндсэн хуулиар баталгаажуулсан эрхийн нэг бөгөөд иргэн бүр улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох, нийгмийн суурь тусламжийг хүртэх эрхтэй. Монгол улс хүн амын дотоод шилжих хөдөлгөөний асуудлыг үндсэн хууль, иргэний бүртгэл, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн баримтаар зохицуулж байна. Бид хувиараа алт олборлогч иргэдийн шилжилт хөдөлгөөнд оролцож буй байдал, тэдгээрийн иргэний бүртгэлийн хамрагдалт, бүртгэлтэй холбоотой асуудлыг энэ бүлэгт харуулав.

Судалгаанд хамрагдсан 100 хувиараа алт олборлогч иргэдийн 78% нь Борнуур сумын уугуул оршин суугчид, үлдсэн 12% нь тухайн орон нутагт шилжин ирж суурьшаад 3 –аас дээш жил болж байгаа иргэд, 8% нь 1-3 жил амьдарч байгаа, 2% нь Борнуур суманд ирээд нэг жил болоогүй байгаа иргэд байлаа. Шилжин ирэгсдээс уг суманд шилжин ирсэн шалтгааныг нь тодруулахад 84% нь алт олборлох, 8% нь газар тариалан эрхлэхээр ирсэн, харин үлдсэн 8% нь 2009 оны эхээр хүдэр баяжуулах цех байгуулагдсан учир хувиараа алт олборлохоор ирсэн гэж хариулж байлаа.

Зураг 5. Борнуур сумын дундаж хүн ам ба өрхийн тоо /5 жилийн харьцуулалт/




Сүүлийн 5 жилийн хугацаанд тус сумын өрх, хүн амын тоог харьцуулан харахад өнгөрсөн жилийн хувьд хүн амын тоо өсөх хандлагатай болсон нь харагдаж байна. Үүнийг Хүдэр баяжуулах цех байгуулагдснаар хот руу ажил хайж явсан уугуул иргэд, болон бусад хүмүүс алт олборлох бизнес эрхлэхээр энд шилжин ирсэнтэй холбоотой юм.

Ингэснээр уг цех нь хотын төвлөрлийг сааруулах, хөдөө орон нутагт ажлын байр бий болгон, хөдөөний иргэдийг амьдарч буй орон нутагтаа ажил эрхлэн амьдрах боломжийг дээшлүүлж өгчээ. Ийм байдлаар хөдөө орон нутагт ажлын байр, орлогын эх үүсвэрийг би болгон улс орны хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж байна гэж дүгнэж болох юм.

Мөн судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн 93% орон нутагтаа бүртгэлтэй гэж хариулж байсан. Үүнийгээ түр журмын хүрээнд нөхөрлөлийн гишүүн болох, БУХ ТББ-аар дамжуулан эрх ашгаа хамгаалах, эрүүл мэнд, нийгмийн даатгалыг сайн дураараа төлж төрөөс хэрэгтэй үйлчилгээгээ авах хүсэлтэйгээ холбон тайлбарлаж байсан.

Зураг 6. Иргэний бичиг баримттай эсэх, хувийн жин



Хэдийгээр судалгаанд хамрагдагсад нь орон нутагтаа 97% бүртгэлтэй боловч тэдний ихэнх хувь нь иргэний бичиг баримтын бүрдэл багатай байлаа.

БҮЛЭГ 4

ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ОРЛОГО БА ЗАРДАЛ


Судалгаанд Борнуур сумын хувиараа алт олборлогчдыг хамруулсан бөгөөд тэдгээр бүлэг иргэдийг эдийн засгийн идэвхитэй хүн ам болон орлого олох зорилготойгоор ажил эрхэлж байгаа ажиллах хүч хэмээх ойлголтод хамааруулсан болно.

Судалгаагаар алт олборлох болсон шалтгаан, олж буй орлого, түүний зарцуулалт, хуримтлалын асуудлыг тодрууллаа.

4.1. АЛТ ОЛБОРЛОХ ШАЛТГААН

Хувиараа алт олборлогч нараас алт олборлох шалтгааныг асуухад нэгж оролцогч нэгээс дээш сонголтоор хариулж давхардсан байдлаар дараах хариултуудыг өгсөн. 81.2% нь орлого олох өөр боломж бололцоо байхгүйгээс, 70,1% нь ажлын байр олдохгүй байгаагаас, 60.6% амьжиргаагаа залгуулахын тулд, 23% орон байртай болох буюу амьдрах орчин нөхцлөө сайжруулах, 20.7% хүүхдийнхээ буюу өөрсдийнхөө сургалтын төлбөрийг төлөхийн тулд энэ ажлыг эрхэлж байна гэсэн хариултыг өгч байлаа.

Зураг 7. Алт олборлох болсон шалтгаан



Хувиараа алт олборлогч иргэдийн өдөрт, долоо хоногт, сард олборлодог алтны хэмжээг тодорхойлох замаар тэдний орлогын хэмжээг, цаашилбал сум орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодрууллаа. Үндсэн орд дээр ажилладаг хувиараа алт олборлогч иргэдийн хувьд тэдний өдөрт олборлодог алтны хэмжээг тодорхойлоход нилээд хэцүү байлаа. Яагаад гэвэл үндсэн ордны хувиараа алт олборлогч нар алтны судал хайн хэдэн өдрийн турш ажиллдаг боловч судал олохгүй байх, олсон ч гарц муутай судал байх, эсвэл маш баян судал байх зэргээр олон хоногийнхоо ажлын үр дүнд харилцан адилгүй хэмжээний орлого олдог талаараа тэд илэн далангүй ярьж байлаа.

4.2. АЛТ ОЛБОРЛОЛТЫН ХЭМЖЭЭ, МӨНГӨН ОРЛОГО

Хувиараа алт олборлогсдын хоногт ажилладаг цаг ба долоо хоногт олборлож буй алтны хэмжээ, хувийн жин

Хүснэгт 11. ХАМО нарын ажлын цаг, алт олборлолтын орлого

Сонгогдсон үзүүлэлтүүд	Хүйс		Дундаж
	Эрэгтэй	Эмэгтэй	
Хоногт ажилладаг цаг			
• 1-8 цаг	2%	48%	25%
• 9-14 цаг	76%	46%	61%
• 15 ба түүнээс дээш	22%	4%	13%
Долоо хоногт олборлож буй алтны хэмжээ (грамм)			
• 0 -2 грамм	81%	89%	85%
• -5 грамм	13%	8%	10.5%
• 5 –аас түүнээс дээш	6%	3%	4.5%

Хөдөлмөрийн бүтээмж нь нэгж хугацаанд бий болгосон бүтээгдэхүүн үйлчилгээг хэлдэг бөгөөд алт олборлолтын долоо хоногийн дундаж хэмжээ буюу хөдөлмөрийн бүтээмж нь Сүжигтэй үндсэн ордны алтны судлын олдоц, гарц, ашиглаж тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хүчин чадал, хөдөлмөрийн бүтээмж, ажиллаж буй хүмүүсийн дадлагажилт, ур чадвар, нас хүйс зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг байна. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн хувьд хөдөлмөрийн бүтээмж нь эмэгтэйчүүдийнхээс харьцангуй их байгаа нь харагдаж байна. Мөн зарим үед гарсан зардлаа ч нөхөж чадахгүй байх үе их тохиолддог хэмээн ярьж байлаа.


Хүснэгт 12. Хувиараа алт олборлогчдын орлогын хэмжээ, хувийн жин

Өрхийн сарын орлогын хэмжээ	Сүжигтэй орд
• 0 - 91200 төгрөг	
• 91201 - 150000 төгрөг	4%
• 150001 - 300000 төгрөг	35%
• 300001 – 500000 төгрөг	56%
• 5000001 дээш	5%
Өрхийн сарын дундаж орлого (төгрөг)	360,000төгрөг
Нийт	100%

Борнуур суманд төсвийн болон бусад аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байгаа ажилчдын сарын дундаж 237,000 төгрөг байхад хувиараа алт олборлогч иргэдийн сарын дундаж орлого 360,000 төгрөг байлаа. Эндээс харахад орлого их олох боломжтой, ажил олгогчийн зүгээс дарамт шахалт бага, мэргэжил мэдлэг шаарддаггүй, харьцангуй эрх чөлөөтэй, гэр бүлээрээ хийх боломжтой ажил учир иргэдийн дунд алт олборлох сонирхол түлхүү байна.

Ганцаарчилсан ярилцлагын явцад зарим хувиараа алт олборлогч иргэд өөр аймаг, сумдаас ирж тогтмол 200,000-250,000 төгрөгөөр цалинжин алт олборлодог тухайгаа хуваалцаж байлаа. Нийт судалгаанд хамрагдсан 100 иргэдийн 47 нь зөвхөн бичил уурхайгаас орлого олдог, 41 нь орлогын өөр нэг эх үүсвэртэй байна. Харин орлогын гуравдагч эх үүсвэртэй 12 хүн байна. Бидний ярилцлага хийсэн хүмүүсээс зөвхөн 3 хүн орлогын дөрөвдөгч эх үүсвэртэй гэсэн хариултыг өгсөн.

Зураг 8. Сарын орлого ба зарлага



Кейс-3:

Хүснэгт 13. Кейс 3: Борнуур сумын өрх толгойлсон эмэгтэй иргэн Г-ийн 2007 болон 2009 оны өрхийн амьжиргааны байдалд хийсэн шинжилгээ

2007 оны өрхийн хэрэглээний ерөнхий байдал	2009 оны өрхийн хэрэглээний ерөнхий байдал	Өөрчлөлт
Ам бүл 9-лээ байсан	Одоо ам бүл 6-лаа. 2 хүүхэд тусдаа гарсан	-
2 хүү алтанд явдаг байсан	2 хүү алтанд явдаг хэвээрээ	-
5 ханатай гэрт амьдардаг байсан	Тоосгон байшин нэмж барьсан	☀☀☀
Машингүй	Машингүй	-
Мах килограммаар буюу бага бага хэмжээгээр, мөнгөндөө тааруулан авч хэрэглэдэг байсан	Одоо өвөлдөө идшинд 2 хонь, 1 үхэр иддэг болсон	☀☀☀
Хуримтлал байхгүй	Хуримтлал байхгүй	-
Малгүй	90 толгой малтай	☀☀☀
Мод түлдэг байсан	Одоо ч гэсэн мод түлдэг	-

Энэхүү кейсээс хоёр жилийн хугацаанд иргэн Г-ийн амьдралд чанарын ямар өөрчлөлт гарсан нь тодорхой харагдаж байна. Энэ мэт маш олон хүмүүсийн амьдралд эерэг сайхан өөрчлөлтүүд гарч байгаа хэдий ч амьдралын ухаан, өрхийн орлого зарлагаа тооцох мэдлэг, дадлага дутмагаас олны ярьж заншснаар “Гэртээ ч харихгүй, гэдсээ ч өлсгөхгүйгээр” энэхүү хүнд хэцүү ажлыг хийсээр байгаа нь харагдаж байлаа.


4.3. АЛТ ОЛБОРЛОЛТЫН ЗАРДАЛ

Судалгаанд хамрагдагсдын 38% нь алт олборлох ажилд сард дунджаар 100,000 төгрөгийн зардал гаргадаг гэсэн бол 36% нь 200,000 төг, үлдсэн 26% хувь нь 300,000 төгрөгний зардал гаргадаг. Харин жилийн дөрвөн улирлаас хүдэр олборлох үйл ажиллагаанд хамгийн их зардал гаргадаг улирал бол хавар гэж судалгаанд оролцогчдын 34% хариулсан. Энэ нь хавар уулны цас мөс хайлж, газар гэсэж нуралт үүсэх аюул нүүрэлдэг, мөн уурхайн ам усанд авдагтай холбоотой гэж тайлбарлаж байлаа.

Сарын орлогоос зарлагыг нь хасч үзэхэд судалгаанд хамрагдагсдын 9% нь орлого зарлага нь тэнцэж илүү гарах юу ч үлддэггүй гэсэн бол 13% - д нь зардлаа ч нөхөж чаддаггүй байх тохиолдол байдаг байна.

Хувиараа алт олборлогч иргэд мах, гурил, гоймон, тамхи, зай, гар чийдэн, бээлий, архи, чихэр, амттанд ихэнх мөнгөө зарцуулдаг бөгөөд барааг бөөндөж авдаг буюу нэг удаад ойролцоогоор 100,000 гаруй төгрөгөөр худалдаж авдаг.

Харин сумын энгийн оршин суугчид нэг удаа дэлгүүрээр үйлчлүүлэхдээ өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнээ ихэвчлэн жижиглэнгээр авдаг бөгөөд дунджаар нийт дүн 20000 төгрөг орчмоор авдаг гэж дэлгүүрийн худалдагч нар ярьж байлаа.



Кейс 4.

Хүснэгт 14. Кейс 4

Ярилцлаганд орсон эмэгтэйчүүд хувиараа ашигт малтмал олборлосноор ар гэрийнх нь эдийн засагт эерэг өөрчлөлтүүд гарсанд сэтгэл хангалуун байдаг тухайгаа ярьж байлаа. Тэд анх хувиараа алт олборлож эхлэх үед гамбир, гэдэс иддэг, төмөр ортой, түрээсийн гэрт амьдардаг байсан бол одоо махыг бөөнөөр нь авах, нарийн боов, боорцог худалдан авах, өвөлдөө идэш идэх, өөрийн гэсэн орох оронтой, бүр машинтай хүртэл болсон байна. Өмнө нь хүүхдийн 3,000 ба 25,000 төгрөгний дэвтрээ барьцаанд тавьж дэлгүүрээс бараа зээлж авдаг байсан бол одоо хүүхдүүдийнхээ их, дээд сургуулийн төлбөрийг төлдөг болсон тухайгаа ярьж хувиулцаж бйалаа. .

Үүнээс гадна, алт олборлож эхлэхээс өмнө мөнгөгүй, бас ажилгүй учир гэр бүлд хэрүүл маргаан их гардаг, нөхөр байнга архи уудаг байсан бол одоо энэ асуудал бүрэн зогсож олсон орлогоо хэрхэхээ нөхөртэйгээ хэлэлцэж шийддэг болсон

хувиараа алт олборлогч эмэгтэйчүүдтэй хийсэн ФБ-ын тэмдэглэлээс


4.4. АЛТ БОРЛУУЛАЛТ БА ХУРИМТЛАЛ

Олборлосон алтаа борлуулах, түүнийг хадгалахтай холбогдсон зарим асуудлыг судаллаа. Хувиараа алт олборлогч иргэдийн 94% нь олборлосон алтаа ХАМО ХК-д, 4% нь дэлгүүрт, 2% нь явуулын ченжүүдэд борлуулдаг гэж хариулсан. Эндээс харахад ХАМО ХК нь хувиараа алт олборлогч иргэдийн олборлосон хүдрийг боловсруулаад гарсан алтыг нь шууд газар дээр нь худалдан авдаг байна. Харин ХАМО ХК нь худалдаж авсан алтаа цааш нь яаж борлуулдгийг танадалтын аргаар судалсан боловч тогтоож чадсангүй.

Харин судалгаанд хамрагдагсдын 62% нь өөрсдийн олборлосон алтаа ченжүүдэд зарж борлуулах сонирхолтой, 32% нь орон нутгийн банкинд, дөнгөж 4% нь хүдэр баяжуулах цех буюу ХАМО ХК-д зарж борлуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Энэ нь нэг талаас ХАМО ХК-ний худалдан авдаг үнэ ханшийн талаар мэдээлэл бага, бас шууд болон шууд бусаар үзүүлдэг дарамттай нь холбоотой байх магадлалтай.


Судалгааны явцад ХАМО ХК-ний алт худалдан авдаг ханшийш тухайн өдрийн дэлхийн болон Монгол Банкны ханштай харьцуулан үзэхэд нилээд байлаа. Энд хоёр үндсэн шалтгаан байх талтай 1) уг ханшинд алтны гэнэтийн ашгийн татвар ороогүй дүн 2) орон нутагт хүдэр баяжуулах үйлчилгээ үзүүлж байгаа гэсэн давуу эрхээ ашиглан алт худалдан авах тал дээр монопольчилж байгаа хандлага байна. Мөн алтаа борлуулахаас татгалзсан хүний хүдрийг цаашид боловсруулж өгөхөөс татгалзах түүнчлэн хүдэр олборлохоор уурхайд гарах үед нь зээлээр бараа олгохгүй байх зэргээр ХАМО ХК нь дарамталдаг гэж хүмүүс ярьж байлаа.

Зураг 9. Хуримтлал үүсгэж чадахгүй байгаа шалтгаан



Судалгаанд оролцогчдоос орлогоосоо мөнгө хадгалах боломжтой эсэх талаар асуухад 16% нь боломжтой, 84% нь боломжгүй гэж хариулсан. Хувиараа алт олборлогч иргэдээс сүүлийн 6 сард мөнгө зээлсэн эсэхийг асуухад 49,5% нь тийм, 50,5% нь үгүй гэж хариулсан.

Зураг 10. Банкны зээлийн төрөл



Зээл авсан гэж хариулсан иргэдийн 58% нь ахуйн хэрэглээндээ зориулж зээл авсан бол 19% нь алт олборлох гарааны мөнгө олох гэж зээл авсан байна. Харин бусад зорилгууд болох өрөө төлөх, багаж тоног төхөөрөмж авах, хүүхдийн сургалтын төлбөр төлөх, байр орон сууц, машин унаа авахад зарцуулсан хэмжээ бага хувийг эзэлж байна. Энэ нь хувиараа алт олборлогч иргэдийн амьдралын түвшин доогуур байгааг илтгэж байна.

Алт олборлож буй иргэдийн орлого мөнгөний эргэлт харьцангуй өндөр боловч олсноо хэрэглэж зарцуулах, өдөр тутмын болон хүнсний тансаг хэрэглээнд үрэх байдал ажиглагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “иргэд хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэж заасны дагуу хувиараа ашигт малтмал олборлогч иргэд ч эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.

БҮЛЭГ 5

АЛТ ОЛБОРЛОЛТ БУЮУ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Энэ бүлэгт хувиараа алт олборлогчдын олборлолтын үйл ажиллагааны ерөнхий байдал, ажлын байрны хүчин зүйлс, түүнийг үүсгэж байгаа нөхцөл, ашиглаж байгаа гар багаж, тоног төхөөрөмж, олборлолтын ажилд учирч байгаа бэрхшээл зэргийг тодорхойлох зорилгоор мэдээлэл цуглуулж боловсруулалт хийлээ. Аливаа үйлдвэрийн өрсөлдөх чадвар нь өндөр сайн менежмент, тэргүүний технологи, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах үр ашигтай систем гэсэн гол гурван хүчин зүйлээр тодорхойлогддог бол бичил уурхайн үйл ажиллагаа ч гэсэн энэхүү өрсөлдөх чадварыг бий болгохын төлөө ажиллах ёстой юм.

5.1. СҮЖИГТЭЙ УУЛАН ДАХЬ АЛТ ОЛБОРЛОЛТЫН БАЙДАЛ

Сумын төвөөс Сүжигтэй уул нь 30 километрт оршдог. Энд нэгийн ам, жарын ам, Мөстэй 1, Мөстэй -2, Хадагтай, Таванжингийн ам болон бусад шинээр гаргасан 10–аад уурхайн ам байна. Нэгийн аманд гэрэлтүүлэг, агааржуулалт байхгүй бүхэлдээ нуранги үүсэн учраас одоогоор олборлолт хийгээгүй байсан. Харин Мөстэй, Хатагтай, Жарын ам уул геологийн нөхцөл хүндтэй шаардлагатай бэхэлгээ доторлогоог хийхгүй бол эдгээр амнуудаас хүдэр олборлох нь маш аюултай болсон байна. Судалгааны багийнхнийг очиход 100 –аад хүн хүдэр олборлож байлаа. Борнуурын сумын төвөөс Сүжигтэй уулын хооронд хувийн машин байнга явдаг, уулнаас сумын төв ороход нэг хүн хоёр мянган төгрөг, нэг шуудай хүдэр 1000 төгрөгийн хөлстэй тээвэрлэдэг гэж бүлгийн ярилцлагад орсон хүмүүс ярьж байлаа.


ХАМО ХК нь нэг тэрэг хүдрийг 13,500 төгрөгөөр буюу тоннын 135,000 боловсруулдаг. Гэхдээ ХАМО ХК-аар үйлчлүүлэгчдийн тоо олон байдаг. Зөвхөн Борнуураас бус, Заамар, Зүүнхараа, Баруунхараа, Баянхонгор, Өмнөговь зэрэг бусад аймаг сумдуудаас их хэмжээний хүдэр ирдэг учир үйлчлүүлэгчид 2-3 хоног үйлчилгээний дараалалд зогсон хүлээдэг гэж хувиараа алт олборлогч ирдэг ярьж байлаа.

Энд олборлолт явуулж байгаа хүмүүийг 2 бүлэгт ангилж болохоор байна. Үүнд:

1. *Байнгын* – Энэ бүлэгт жилийн 4 улирлын турш байнга ажилладаг, үндсэн ажил эрхлэлт нь хувиараа алт олборлолт болсон бүлэг хүмүүсийг хэлдэг
2. *Түр зуурын* – Энэ бүлэгт цөөн хоногоор ирээд 1-2 удаа далд уурхайд малталт хийж багахан хүдэр олборлоод буцдаг бүлэг хүмүүс орно

Эдгээр хүмүүс нь амны эзэн гэгдэх хүмүүстэй тохиролцон тэдэнд зохих хөлс төлөн далд уурхайд нь ажилладаг. Иймээс амны эзэн гэгдэх эдгээр хүмүүс ийм замаар өөрийн амнаас орлогоо нэмэгдүүлдэг болох нь ажиглагдлаа.

Зураг 11.ХАМО иргэдийн үйл ажиллагааны дамжлага




Сүжигтэй уул нь сумын төвтэй ойрхон учир Сүжигтэй ууланд гуанз, дэлгүүр, билльярд, теннис, бусад худалдаа, үйлчилгээний газрууд ажилладаггүй. Олборлогч иргэд сумын төвөөс 7-14 хоногийн хэрэгцээт хүнсээ бөөнөөр нь татаж авдаг гэж ярьж байлаа. Харин нөхөрлөлийн гишүүд нь хоорондоо гал болж нэг гэрт амьдардаг байна.

5.2. АЛТ ОЛБОРЛОХ БОЛСОН ШАЛТГААН, ҮР ДАГАВАР

Хувиараа алт олборлогч нараас алт олборлох шалтгааныг асуухад нэгж оролцогч нэгээс дээш сонголтоор хариулж давхардсан байдлаар дараахи хариултуудыг өгсөн. 81.2% нь орлого олох өөр боломж бололцоо байхгүйгээс, 70.1% нь ажлын байр олдохгүй байгаагаас, 60.6% амьжиргаагаа залгуулахын тулд, 23% орон байртай болох буюу амьдрах орчин нөхцлөө сайжруулах, 20.7% хүүхдийнхээ буюу өөрсдийнхөө сургалтын төлбөрийг төлөхийн тулд энэ ажлыг эрхэлж байна гэсэн хариултыг өгч байлаа.


Зураг 12. Алт олборлох болсон шалтгаан



5.3. ХАМО ИРГЭДИЙН АЛТ ОЛБОРЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ХУГАЦАА

Судалгаанд оролцогчдийн дийлэнх хувь алт олборлох үйл ажиллагааг цаашид үргэлжүүлэн хийсээр байна гэсэн ба үүнийг тодруулахад энэ нь аймаг сумын хэмжээнд ажлын байр шинээр бий болохгүй байгаа, нийгэм эдийн засгийн байдалд дорвитой өөрчлөлт орохгүй байгаатай гэж тайлбарлаж байлаа.

Зураг 13. ХАМО иргэдийн алт олборлосон жил



Геологи уул уурхайн чиглэлээр хийгдсэн мэдээ судалгаануудаас болон холбогдох мэргэжлийн хүмүүстэй уулзаж ярилцаж байхад том уул уурхайн компаниудын олборлолтод ашигладаг тоног төхөөрөмжүүдийн ялгаж чадаагүй дутуу олборлогдсон үлдэгдэл алтны нөөц, мөн иом оврын техник тоног төхөөрөмжөөр олборлох боломжгүй, том компаний хувьд эдийн засгийн үр өгөөжгүй нөөцүүд манай орны хувьд их байдаг учир энэ төрлийн бизнес ойрын 20 жилд зогсохгүй гэж үзэж байлаа.

Сүжигтэй уулын амуудад иргэд алт олборлоод арав гаруй жил болсон тул амны ойролцоох гүехэн хэсгийн алтны судалтай хүдрийг олборлоод бараг дууссан ба өнөөдөр олборлогч иргэд нь далд малталтын нилээд гүнээс алттай хүдэр олборлох хэрэгтэй болоод байна. Ийм учраас амнаас хэдий хол ажиллана төвийчинээ агааргүй болох, улмаар агаар багатай нөхцөлд удаан ажилласнаас хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөө бий болох эрсдэл өндөр байна.

5.4. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН АЛТ ОЛБОРЛОЛТ ХИЙХ ЭРХ ЗҮЙН НӨХЦӨЛ, БАЙДАЛ

Судалгааны явцад газрын асуудал нилээд хөндөгдөж байсан бөгөөд өөрсдийгөө Монгол Улсын Засгийн Газрын 72-р тогтоол, түр журамд заасны дагуу зөвшөөрөгдсөн газарт алт олборлолт явуулж байгаа хэмээн нийт оролцогчдын 32% нь хариулсан байлаа. Харин үлдсэн 68% өөрсдийн олборлолт явуулж байгаа газрын зөвшөөрлийн талаар тодорхой мэдээлэлгүй байлаа. Борнуур сумын “Сүжигтэй” ууланд олборлолтын үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөл хувиараа алт олборлогч иргэдэд өгөгдсөн эсэх талаар холбогдох сумын засаг захиргааны удирдах албаны хүмүүстэй уулзаж тодруулахад:

Уг олборлолт хийгдэж байгаа “Сүжигтэй” уулан дахь 58 га газар нь Канадын хөрөнгө оруулалттай “Сентера гоулд” компаний лицензтэй газар боловч тус компани нь тухайн газарт олборлолт хийдэггүй тул хувиараа алт олборлогч иргэд ШХА, Борнуур сумын засаг захиргаа, Бичил Уурхайчдын холбоо төрийн бус байгууллага, “Сентера гоулд” компани, Ашигт малтмалын газрын хамтран хийсэн таван талт хамтын ажиллагааны санамж бичиг дээр үндэслэн олборлолт хийсээр байгаа юм байна. Харин санамж бичиг болон холбогдох хууль журмуудад заасны дагуу орон нутгийн засаг захиргаа, лиценз эзэмшигч хуулийн этгээд болон хувиараа алт олборлогч нарын төлөөллийн байгууллага хувиараа алт олборлогч нарын аюулгүй ажиллагаа, нөхөн сэргээлт, уулын ажлын төлөвлөгөө зэргийг агуулсан нарийвчилсан нөхцөл, заалт бүхий 3 талт гэрээн дээр гарын үсэг зурах шаардлагатай юм байна.

Энэхүү гэрээг талууд харилцан зөвшилдсөний үндсэн дээр хийж баталгаажуулаагүй байгаа тохиолдолд “Сүжигтэй” ууланд алт олборлогч нарын хийж байгаа олборлолтыг хууль бус гэж үзэхээс өөр аргагүй юм. Уул уурхай эрхлэх, ашигт малтмал олборлолтын асуудлыг лицензгүйгээр төсөөлөх боломжгүй учир хувиараа алт олборлогч иргэдийн олборлолтын зөвшөөрлийн асуудлаар төслийг хэрэгжүүлэгч талууд анхааран ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байлаа.

БУХ ТББ-ын удирдлагуудтай Сүжигтэй ууланд олборлолт хийх зөвшөөрлийн асуудлаар уулзаж ярилцахад “Сумын засаг захиргаа, ИХ Сүжигтэй уулыг орон нутгийн хэрэгцээнд авч, хувиараа алт олборлогч иргэддээ гэрээгээр олгох хэрэгтэй гэдэг байр суурьтайгаар ажиллаж байна. Ойрын үед энэхүү асуудлыг шийднэ” гэж ярьж байв.

5.5. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ НАРЫН АЖЛЫН АЧААЛАЛ, АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ

Судалгаанд оролцсон иргэдийн 78% нь алт олборлох үйл ажиллагааг байнга хийдэг гэж хариулсан ба үлдсэн 22% нь мөнгө хэрэг болсон үедээ олборлолт хийдэг гэсэн байна. Алт олборлох үйл ажиллагааг хоногт хэдэн цаг хийдэг талаар тодруулахад хувиараа алт олборлогч нар доорх мэдээллийг өгч байлаа.

Хүснэгт 15. ХАМО иргэдийн ажлын цаг

Сонгосон үзүүлэлт	Эзлэх хувь
8 хүртэл цаг	2%
8-12 цаг ажилладаг	76%
13-аас дээш цаг	22%
Нийт	100%

Хүдэр олборлох ажлынхаа хэдий хугацааг газар дор ажиллаж өнгөөрдөг талаар судлахад тэдний асуулгад оролцогч иргэд “Бидний хайж байгаа зүйлс газар доор л байдаг учир ажиллаж байх хугацааныхаа 90%-ийг газар доор өнгөрөөдөг. Зөвхөн амрах, хоол унд идэх үедээ л газар дээх гарч ирдэг” гэж байлаа.

Ёаёё 5

Би нэг удаа газар доор алтаа судлаа манаад, хүдрээ ухаад бараг 10 хоног газар дээр гаралгүй байж үзсэн.

24 настай Д

Хавар цас хайлах, шар усны үер буух зэргээр тунелүүд усаар дүүрч, зарим тохиолдолд бэлхүүсээр татсан их устай болдог учир хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл байхгүй хувиараа алт олборлогч нарт хамгийн хэцүү байдаг талаар судалгаанд оролцогч нар ярьж байлаа.

5.6. АЛТ ОЛБОРЛОГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэд өөрсдийгөө маш хүнд хэцүү, ажлын байрны тав тух, аюулгүй байдлын наад захын хэрэгцээ шаардлагад нийцээгүй хамгийн их эрсдэл дагуулсан нөхцөл байдалд ажилладаг гэдгээ мэддэг ч үүнээс өөр сонголт, орлого олох боломж бололцоо байхгүй учраас энэхүү ажлыг хийсээр байгаагаа ярьж байлаа.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сургалт, хичээлүүдэд сууж байсан хэдий ч нөхөрлөлийн бүх гишүүд нэгдсэн ойлголт, бүрэн зохион байгуулалтад орж чадаагүй, сурсан зүйлээ амьдрал дээр төдийлөн сайн оновчтой хэрэглэж чадахгүй байгаа тухайгаа дурьдаж байлаа.

Хүснэгт 16. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх мэдлэг мэдээлэл



Алт олборлож байгаа бараг бүх иргэд ажлын хувцас хэрэглэдэг гэж хариулж байгаа боловч энэ нь уул уурхайн ажилд зориулагдсан тусгай хувцас биш өдөр тутам хэрэглэдэг хувцсаа хэрэглэж байлаа. Нийтийг хамгаалах ямар ч хэрэгсэл байхгүй харин хувийн хамгаалах хэрэгслийн хувьд хэрэглэхээс аргагүйд хүрдэг усны гутал, резинэн бээлий, амны хаалт, ажлын бээлий зэргийг хэрэглэж байна.

Үндсэн орд дээр ажиллаж байгаа хувиараа алт олборлогч нарын хувьд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны ямар хувцас, хэрэгсэл нэн тэргүүнд хэрэгцээтэй байдаг, мөн өөрсдийн аюулгүй байдлаа хамгаалахын тулд ямар хувцас хэрэгслийг тогтмол хэрэглэдэг талаар доорхи мэдээллийг өглөө.

Хүснэгт 17. Хувиараа алт олборлогчдын хэрэглэдэг ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл


#	Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл	Хувь
1	Ажлын өмд, цамц	100%
2	Зузаан өмд цамц	100%
3	Каска	19%
4	Дулаан малгай	100%
5	Ажлын гутал	100%
6	Эсгий гутал	45%
7	Усны гутал	100%
8	Резинэн бот, шаахай	-
9	Ажлын даавуун бээлий	100%
10	Дулаан бээлийн	100%
11	Резинэн бээлий	59%
12	Нүд хамгаалах шил	-
13	Чихний бөглөө, чихэвч	-
14	Амны хаалт, маска	54%
15	Тоосноос хамгаалах хушуувч	-
15	Хамгаалах бүс бусад	10%
	Оролцсон хүмүүс	100 хүн

Дандаа тоос шороотой нөхцөлд ажилладаг учир тэдний хувьд хамгийн хэрэгцээтэй зүйл нь маск байдаг хэдий ч агааргүй, битүү орчинд ажилладаг болохоор тэр болгон шаардлагад нийцсэн маскыг байнга, цэвэр хэрэглэх, худалдан авах боломжгүй байдаг учраас өдөр болгон хэрэглээд байж чаддаггүй гэж хариулж байсан. Хамгаалах нүдний шил, усны гутал, бэхлэгч, ажлын гутал, бээлий, каск зэрэг хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл, хувцас зэрэг нь хэдийгээр тэдний ажил хөдөлмөр эрхлэлтэд маш их хэрэгтэй байдаг хэдий ч тэр бүр хэрэглээд байж чаддаггүй.

Харин толгойн гэрэл, бэхэлгээний олс зэрэг багаж нь тэдний үйл ажиллагаанд зайлшгүй чухал шаардлагатай байдаг учир байнга хэрэглэхээс өөр аргагүйд хүрдэг гэж ярьж байлаа.

Эдгээр багаж хэрэгслүүдийг хэрэгцээтэй гэдгийг мэддэг хэдий ч яагаад хэрэглэж чадахгүй, хэвшихгүй байгаа талаар нь судалж үзэхэд эдгээр ХХАА-ны багаж хэрэгсэл, хувцасны олдоц орон нутагт төдийгүй Улаанбаатар хотод ч ховор, хаана зарагддаг талаарх мэдээлэл сурталчилгаа муу, үнэ өндөр байдаг гэж байлаа. Мөн Монголд худалдаалагдаж байгаа ХХАА-ны хувцас хэрэгсэл нь хэрэглэхэд тохиромжгүй, ажил хийхэд тээртэй, чанар муутай учир хэрэгцээ шаардлага хангадаггүй тухай ярьж байлаа.

Зураг 14.Хөдөлмөр хамгааллын хувцасны олдоц, хүртээмж



Харин багаж хэрэгслийн хувьд тэд ярихдаа аль болох хүмүүсийн гар ажиллагаа, хөдөлмөрийг хөнгөвчилсөн багаж, тоног төхөөрөмж хэрэглэхийг хүсдэг ч санхүү мөнгөний боломжгүйгээс шалтгаалан авч хэрэглэж чаддаггүй. Чулуун ордод ажиллахад хамгийн хэрэгцээтэй тоног төхөөрөмж бол компрессор буюу цохилтот өрөм, шат, сков, леботик зэрэг багажууд тэдний ажлыг нилээд хөнгөвчилдөг. Эдгээр багажуудыг худалдан авч чадахгүй тохиолдолд тэд бусдаас түрээслэн авах, эсвэл тоног төхөөрөмж сайтай нөхөрлөлүүдэд хөлсөөр ажилладаг байна.

Ердийн гар багажуудын хувьд тэд байнга хэрэглэдэг бөгөөд өөрсдөө худалдан авч хэрэглэх боломжтой ба эвдэрсэн тохиолдолд гагнах, хадах зэргээр засдаг.

Судалгаанаас үзэхэд үндсэн ордоос алт олборлож байгаа хүмүүс өрөмдөх тэсэлгээ хийх хүдрээ ухаж гаргах, үүрч зөөх, машинд ачиж буулгах, хүдрээ тээрэмдүүлэх зэрэг арав гаруй төрлийн нийтлэг ажил хийдэг бөгөөд үүнийг нэг хүн бүгдийг хийдэггүй. Тухайн ажил үүргийг гүйцэтгэх хуваарьтай байдаг байна.

Жишээ нь өрөмдлөг тэсэлгээний ажлыг цөөн тооны дадлага туршлагатай хүмүүс хийж байна, харин чулуугаа ухаж авах, үүрч зөөх ачиж буулгах

зэргийг ихэнхдээ залуучууд байна. Тээврийн ажлыг хувийн машинтай хүмүүс тээвэрлэлтийн хөлс аван гүйцэтгэдэг байна.

Хүснэгт 18. Ажлын байрны хортой хүчин зүйлийн түвшин

№	Хортой хүчин зүйлс	Хүний тоо	Их (муу)		Дунд зэрэг		Бага (сайн)	
			тоо	%	Тоо	%	тоо	%
1	Тоос	168	110	66.5	56	33,5%	-	-
2	Шуугиан	168	13	7,9%	93	55,4%	62	36,7
3	Доргио	168	8	5	88	52,2	72	42,8
4	Агаарын хүрэлцээ	168	83	49,7	48	28,4	37	21,9
5	Хортой хий, бодис	168	10	6,1%	37	22,3	121	71,9
6	Гэрлийн хүрэлцээ	168	128	76,3%	22	12,9	18	10,8
7	Биеийн хүчний ачаалал	168	109	65,1%	53	31,7	5	3,2
8	Сэтгэл санааны дарамт	168	62	36,7%	59	34,9	48	28,4
9	Согтууруулах ундаа хэрэглэх	168	18	10,5%	71	42,4	79	47,1
10	Ажлын цагийн үргэлжлэл	168	120	71,6%	48	28,4	-	-

Бүлгийн ярилцлагад оролцсон иргэд тоостой, харанхуй орчинд, айдас хүйдэстэй биеийн хүчний ачаалалтай ажлыг удаан хугацаагаар хийдэг гэж хариулж байлаа.


Хүснэгт 19. ХАМО нарын алт олборлоход хэрэглэдэг багаж хэрэгсэл

	Ажлын багаж	Хувь
1	Хүрз	100
2	Жоотуу	95,2
3	Алх	83,3
4	Гадас	83,3
5	Лантуу	76,2
6	Лоом	78,6
7	Хусуур	71,4
8	Шуудай	100
9	Гар дамнуурга	42,9
10	Олс дээс	100
11	Хувин	100
12	Түмпэн	97,6
13	Дамнуургат татлага	19,0
14	Уур нүдүүр	0
15	Лаа	76,2
16	Гар чийдэн	100
17	Сков	69,0
18	Бусад	33,3

Үндсэн ордны хувьд илүү механикжсан байдал ажиглагдсан бөгөөд агааржуулах зорилгоор компрессор, чулуу өрөмдөх зориулалттай тэсэлгээний төхөөрөмж зэргийг ашиглаж байна. Үндсэн ордод тохиоддог бас нэгэн өвөрмөц, шийдэхэд хүндрэлтэй эрсдэлтэй зүйл бол тэсэлгээний асуудал болох нь судалгааны явцад харагдаж байлаа. Хад, чулууг хагалж бутлахдаа тэсэлгээг хэнээр хийлгэдэг талаарх асуултанд оролцогчдын 79% туршлагатай хувиараа алт олборлогч нараар хийлгэдэг.

Харин үлдсэн хувь нь тэсэлгээний эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гэж хариулсан боловч аль компаниас ихэвчлэн үйлчилгээ авдаг талаар тодруулахад үйлчилгээ үзүүлдэг компанийхаа нэрийг сайн мэдэхгүй байлаа. Мөн тэсэлгээтэй холбоотой ямар хүндрэлтэй асуудал байгаа талаар сонирхоход доорхи байдлаар хариулж байлаа.

Зураг 15. Тэсэлгээтэй холбоотой гардаг хүндрэлүүд



Энэ асуудлыг хэрхэн шийдвэл зохих талаар тэдний саналыг асуухад оролцогч нарын 56% орон нутгийн компаниудад тэсэлгээний эрхийг өгөх, 17% хувиараа алт олборлогч нарын дундаас мэргэжлийн тэсэлгээчнийг бэлтгэх, 27% нь аюулгүй ажиллагааны дүрмийг сайжруулж тэсэлгээний талаар болон тэсэлгээний үеийн уурхайд мөрдөх дүрэм, журмуудыг сайжруулан энэ талаар хувиараа алт олборлогч нарыг сургах шаардлагатай гэсэн санал дэвшүүлж байлаа.

Олборлосон хүдрээ хэрхэн баяжуулдаг талаар хувиараа алт олборлогч нараас тодруулахад тэд 100% ХАМО компаниар үйлчлүүлдэг, алт баяжуулахдаа мөнгөн ус хэрэглэдэггүй гэж хариулсан.

Хүснэгт 20. Алт олборлолтыг сурсан байдал

	Ажил үүрэг		Хувь
1	Уул уурхайн дээд боловсролтой		-
2	Уул уурхайн тусгай дунд боловсролтой		-
3	Уул уурхайн тусгай мэргэжилтэй		4,8%
4	Мэргэжилгүй		95,2%
5	Үүнээс	1. Туршлагатай хүмүүсийг дагалдаж сурсан	80,2%
6		2. Курс дамжаанд сурсан	-

7		3. Төслийн багийнхан сургасан	-
8		4. Өмнө нь алт олборлох үйлдвэрт ажиллаж байхдаа сурсан	4,8%,
9		5. Бусдыг хараад сурсан	10,2%

БҮЛЭГ 6

ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Хүн ямар ч үед эрүүл мэндийнхээ төлөө санаа тавих эрүүл мэндээ хамгаалуулах эмнэлгийн тусламж авах эрхтэй.

Энэ тухай Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах хэрэгтэй. Иргэдэд эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үзүүлэх болзол журмыг хуулиар тогтооно “ гэж баталгаажуулсны дагуу уг харилцааг эрүүл мэндийн тухай, иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, эмийн тухай, ариуйн цэврийн тухай зэрэг болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна. Иргэд эрүүл мэндийн даатгалтай нөхцөлд холбогдох хууль журамд заагдсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдана.

6.1. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдагсдын 30 гаруй хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд эмнэлгийн тусламж авсан гэж хариулжээ. Энэ нь харьцангуй идэр насны залуучууд ажилладагтай уялдан эмнэлгийн тусламж авах хэрэгцээ бага гарсан гэж үзэхээс гадна яаралтай амь насанд аюул учруулсан тохиолдлоос бусад үед эрүүл мэндийн байгууллагад хандах урьдчилан сэргийлэх үзлэг зөвлөгөө авах хандлага сул байдагтай холбоотой нь ажиглагдлаа. Түүнчлэн иргэд эрүүл мэндийн даатгалын хууль, төрөөс хариуцах эрүүл мэндийн тусламжийн талаар дутуу дулимаг мэдлэгтэйгээс өөрт шаардлагатай

Зураг 19. 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, цэвэр өсөлтийн харьцуулалт

тусламжийг авч чадахгүй байна.



Алт олборлодог иргэдийн эрүүл мэндийн байдалтай холбоотой тодорхой өөрчлөлтүүд сүүлийн жилүүдэд нилээд ажиглагдаж байгаа тухай судалгаанд оролцогч иргэд мэдээлж байсан. 2000-2007 оны үед бие загатнах, толгой өвдөх, хумс хонхойх, үе мөч янгинан өвдөх зэрэг зовиурууд нийтлэг илэрдэг байсан бөгөөд эдгээр нь өмнө байсан мөнгөн усны хэрэглээ, ажлын байрны тав тухгүй орчин, хоол хүнсний хэрэглээ ба чанартай холбоотой гэсэн таамаглалыг бүлгийн хэлэлцүүлгийн үед дэвшүүлж байлаа.

Кейс 5


Мөнгөн усны хэрэглээ хоригдохоос өмнө би нөхөртэйгөө мөнгөн ус хэрэглэн алт бариулдаг байсан. Би сүүлийн 4 жил дараалан хүүхэд тээсэн боловч хүүхэд маань 1-4 сардаа эндээд байх юм. Энэ бол яах аргагүй мөнгөн ус хэрэглэдэг байсантай холбоотой гэж би боддог.

35 настай, эмэгтэй иргэн Э

Харин хувиараа алт олборлох үйл ажиллагааг түр журмаар зохицуулж, мөнгөн усгүй технологийг Борнуур суманд нэвтрүүлсэн нь хувиараа алт олборлогч иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байсан хүчин зүйлийг зогсоосон байна. Борнуур сумын иргэд мөнгөн усны хордлогоноос айх айдасгүй, амар тайван амьдрах болсон нь судалгааны явцад ажиглагдлаа. Гэхдээ хувиараа алт олборлогч иргэдийн 84%-д нь алт олборлож эхэлснээс хойш цээжээр хатгуулан ханиалгах зовиур илэрдэг болсон нь тэдний агааргүй, тоосжилттой, хүйтэн, чийгтэй орчинд ажиллаж байгаагаас үүдэлтэй байж болох юм.

Хувиараа алт олборлож байгаа хүмүүсийн дунд хүнд архаг өвчин одоогоор байхгүй гэж байгаа боловч ихэнх хүмүүс хүйтэн чийгтэй газар ажилладаг учраас ядардаг, даардаг гар хуруу сайртаж хагардаг, зарим үед хагаран цус гардаг, үе мөч бөөр өвдөх явдал гардаг, хоолой сөөж өвчилдөг, түр хугацаагаар өвчилж эм тан ихээр уух, эмнэлгийн үйлчилгээ ойр байдаггүй зэрэг зүйлсийг бүлгийн ярилцлагын үеэр ярьж байлаа.

Зураг 16. Хувиараа алт олборлогч иргэдэд илэрдэг өвчлөлийн нийтлэг зовиур



Үүнээс гадна, Сүжигтэй ууланд алт олборлодог болсноос хойш сүрьеэ өвчний тохиолдол Борнуур суманд илэрдэг болсон тухай сумын эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд онцолж байна. хувиараа алт олборлогч нар уушигны сүрьеэ, бөөр, нурууны өвчнөөр өвдөх хандлага түлхүү ажиглагдаж даралт ихсэх, ходоод гэдэс өвдөх тохиолдол нийтлэг гарч байна.

Тус суманд 14 сүрьеэгийн тохиолдол гарсан ба өвчлөгсдийн 10 нь хувиараа алт олборлогч иргэд байжээ. ХАМО иргэд нойр хоолгүй ажиллаж, хүйтэн чийгтэй нөхцөлд удаан хугацаагаар ажилладаг, ханиад хатгаа авсан ч эмчилгээ хийлгэлгүй хүндрүүлснээр сүрьеэ тусах, гэр бүлийнхэндээ халдаахад хүрч байна.

Гэхдээ эм тариагаа тогтмол ууж хяналтанд орж чадвал эдгэрэх магадлал өндөр байдаг талаар эмч нар ярьж байлаа. Хэдийгээр хувиараа алт олборлогч иргэд эмчилгээний үед буцаад алт олборлож эхэлдэг ч энэ нь эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлдөггүй. Учир нь сумын эмнэлэг урьдчилан сэргийлэх үзлэгийг сүрьеэгийн халдвар авсан байж болох сэжигтэй хүмүүст тогтмол явуулж эрт оношилж эмчилгээг цаг алдалгүй эхэлдэг байна.

Хүснэгт 21. Хувиараа алт олборлогч нарын өвчлөлийн байдал

	Өвчлөлт	Илэрсэн тохиолдол
1	Силикоз	-
2	Антракоз	-
3	Тоосны гаралтай бронхит	11
4	Бөөрний өвчин	17
5	Мөнгөн усны хордлого	-
6	Үе мөчний өвчин	49
7	Мэдрэлийн өвчин	18
8	Тоосны гаралтай харшил	22
9	Чих, хамар, хоолойн өвчин	37
10	Арьсны үрэвсэл харшил	29
11	Сүрьеэ	10
12	Бусад	12

6.2 ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ОСОЛ ГЭМТЭЛД ӨРТӨЖ БУЙ БАЙДАЛ

Судалгаанд оролцсон хувиараа алт олборлогч иргэдийн 68% нь гэмтэж байгаагүй, 18% нь гэмтэж байсан, 14% нь осолд орж байсан гэж хариулжээ.

Хүснэгт 22. Хувиараа алт олборлогч нарын дунд нийтлэг тохиолддог гэмтлийн төрлүүд

	Ажил үүрэг	Тохиолдол иар	%-
1	Нүх нурж дарагдсан	3,5%	
2	Малталтын дээвэр нурсан	5,2%	
3	Нүхэнд унасан	8,4%	
4	Өндрөөс унасан	2,1%	
5	Юм мөргөсөн	-	
6	Түлэгдсэн	2%	
7	Хурц хордсон	-	
8	Машинд дайруулсан	1,5%	
9	Бусдад зодуулсан	7,5%	
10	Тэсэлгээнд өртсөн	-	
11	Хүйтэнд хөлдөх	-	
12	Согтуурсны улмаас гэмтэх	-	
13	Угаартсан	12,1%	
14	Бусад	7,1%	

6.3 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН БАЙДАЛ

Сүжигтэй ууланд алт олборлогч иргэд эрүүл мэндийн үйлчилгээнд хэрхэн хамрагдаж буйг тандан судлахад тэдний 52% нь найз нөхдөөсөө буюу ууланд хамт алт олборлодог хүмүүсээс эмнэлгийн тусламж авдаг гэжээ.

Мөн уурхай дээр ажиллаж байх үедээ хэрэгтэй эм тариагаа сум руу хүн явуулж авахуулдаг гэсэн хариултын 72% нь, өөрсдөө ууланд гарахдаа авч очдог гэж 16% нь, 12% нь бусдаас авдаг гэсэн байлаа. Үүнээс үзэхэд хувиараа алт олборлогч иргэд тэр болгон эмнэлэгт хандаад байдаггүй, аль болох өөрийгөө бие даан эмчлэх хандлагатай байна.

6.4 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ

Борнуур сумын эмнэлэг 10 ортой, 31 ажилчинтай, үүний 4 нь их эмч, 10 нь эмнэлгийн дунд мэргэжилтэй, бусад нь үйлчилгээний ажилчид байна. Улсаас эмнэлэгт олгодог төсөв нь уг сумынхаа хүн амын тоогоор тооцогддог хэдий ч өөр аймаг, сумдаас ирж алт олборлож байгаа хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлэхээс өөр аргагүй болдог тухай эмч мэргэжилтнүүд ярьж байсан.

Сумын эмнэлгийн хувьд тэд хүдэр боловсруулах цех дээр сард нэг удаа очиж урьдчилан сэргийлэх үзлэг хийдэг тул хувиараа алт олборлогч иргэд өвчнөө цаг алдалгүй оношлуулах боломжтой байдаг. Харин ууланд алт олборлож байгаа иргэн ямар нэг осол аваарт өртөхөд эмнэлгийн яаралтай тусламжийг цаг алдалгүй авахад машин тэрэгний хүртээмж, шатахууны хүрэлцээтэй байдлаас хүндрэл гардаг нь харагдаж байсан.

Судалгаанд хамрагдсан хувиараа алт олборлогч иргэдийн 52% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан нь БУХ ТББ-ын үйл ажиллагааны үр дүн юм. Гэсэн хэдий ч уурхайд осол болоход эмнэлгийн яаралтай тусламжийг 3 цагийн дотор авч чадна гэж хувиараа алт олборлогч иргэдийн 22%, 4-5 цагийн дотор гэж 68% нь сонгосон бол 6-аас дээш цагийн дараа гэж 10% нь хариулжээ. Энэ нь эмнэлгийн тусламжийг богино хугацаанд авч чадна гэсэн итгэл хувиараа алт олборлогч иргэдийн дунд маш сул байгааг харуулж байна.

Зураг 17. Эрүүл мэндийн үйлчилгээ авахад гардаг бэрхшээл



БҮЛЭГ 7

ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

7.1. ХУВИАРАА АЛТ ОЛБОРЛОГЧ ИРГЭДИЙН ДУНДАХ НӨХӨРЛӨЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Санал асуулгын судалгаанд оролцсон алт олборлогч иргэдийн 87% нь ХАМО нарын хамтын ажиллагааны хэлбэр болох бүртгэгдээгүй нөхөрлөлийн талаар тодорхой мэдлэг, ойлголттой байсан ба үлдсэн 13% нь энэ талаар мэдээлэлгүй байлаа. Нөхөрлөлийн зохион байгуулалтын талаар мэдээлэл бүхий иргэдийн 58% нь бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн байсан ба энэ зохион байгуулалтын дагуу алт олборлох үйл ажиллагаа эрхэлдэг гэж хариулжээ.

ХАМО нар нь Иргэний хуулийн 481.1 –д заасны дагуу хамтран ажиллах гэрээ байгуулан бүртгэгдээгүй нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулагдаж байна. Алт олборлох газрын асуудлаар сумын засаг даргатай гэрээ байгуулан ашигт малтмалыг гар багажаар болон бага оврын техник тоног төхөөрөмж ашиглан алт олборлох үйл ажиллагаа явуулж байна. ХАМО нар нь бүртгэгдээгүй нөхөрлөл хэлбэрээр хөдөлмөрөө хоршин ашиг олох зорилгоор байгуулдаг. Бүртгэгдээгүй нөхөрлөл нь гишүүнчлэлтэй хуулийн этгээдийн эрхгүй, хамтын хөдөлмөрийн хэлбэр юм байна.

Нөхөрлөлийн гишүүд нь дараахь шаардлагыг хангах ёстой байдаг юм байна.

1. Монгол Улсын иргэн байх
2. 18 насанд хүрсэн байх
3. Борнуур сумын байнгын оршин суугч байх
4. Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй иргэний орлогын албан татвар төлөгчийн гэрчилгээ авсан байх
5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдсан байх
6. Нөхөрлөлийн гишүүн зөвхөн нэг нөхөрлөлд хамаарагддаг байх


Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журамд зааснаар нөхөрлөлийн гишүүдийн тоо 2-оос 100 хүртэл байх ёстой хэдий ч Борнуур сумын бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүдийн дундаж тоо нь 5-10 байлаа. Судалгаанд оролцогчид нөхөрлөлийн гишүүд хөдөлмөрөө хорших, хамтын аюулгүй ажиллагаагаа сахин ажиллах, ажил үүргээ хуваарилах, ашиг орлогоо хуваах, дундын сан байгуулах, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, дотоод хяналт тогтоох, шаардлага тавих, аливаа зөрчлийг арилгах зэрэгт хамгийн тохиромжтой нөхөрлөлийн бүтэц бол 8-12 хүртэл гишүүнчлэлтэй байх явдал гэж ярьж байлаа.

Кейс 7.

Хүснэгт 23. Кейс 7

Ярилцагч: Н, 53 настай **Гэр бүлийн байдал:** Эхнэр, 4 хүүхэд, хадам ээжийн хамт амьдардаг. Гэр бүл нь сумын төвийн Мандал багт амьдардаг. **Хөдөлмөр эрхлэлтийн байдал:** 1998 оноос хойш “Сүжигтэй” ууланд алт олборлож байна. Баян-өлзийт нөхөрлөлийн гишүүн. Би анх энэ нөхөрлөлд сайн дураар элсээгүй. Нөхөрлөлд элсэхгүй бол хууль бус алт олборлолт гэж үзээд зогсоох арга хэмжээ авна гэсэн яриа манай энэ хавиар гарч, хоолноосоо салахгүйн эрхэнд орж байлаа. Эхэндээ хүмүүсийн байр байдлыг ажиглаж хий гэснийг нь хийж, орлогоо хуваарилахад нь одоо яадаг бол гэж эргэлзэж байсан. Эхний 2 долоо хоногт учраа олохгүй, хүмүүс яана..., түүнийг нь дагаад л хийдэг байлаа. Харин одоо байдал арай өөр болж байна. Ядаж л олсон жаахан хүдрээ хүмүүст алдчих айдас байхгүй, хоол, галгүй болчихгүй нэг талаараа сэтгэл амарсан гэж болно. Ажиллах үедээ ажиллаад, хоол, тамхи нь бэлэн сайхан байна. Өмнө нь яг нөхөрлөл биш ч хүмүүс хамаатан садан, танилаараа нийлж ажилладаг байсан. Ууланд хүн болгон даарна, өлсөнө, хэн түрүүлж буусан нь байгаа хоолоо идээд үлдсэн хэд нь тамхи архиар өл дардаг байлаа. Өөрийнхөө хүдрийг бусдад алдчихгүй гэртээ авч очно гэдэг бас амаргүй. Хүдрээ манаад шөнөжин хүйтэн гэрт нойргүй хонодог байсан. Архи уулаа, олсон хүдрээ согтуу толгойлж алдлаа, санаа зовоод гээд эхнэр маань байнга үглэдэг байсан бол миний өмнөөс унац (орлого)-ыг маань ирээд авчихдаг болохоор өөрт нь их амар байх шиг байгаа юм.

Зураг 18. Нөхөрлөлийн давуу талууд



Хувиараа алт олборлох ажил нь эрсдэл ихтэй, өдрийн ихэнх цагийг хүнд, хортой нөхцөлд өнгөрүүлэх шаардлагатай болдог учраас бусадтай хүч, нөөцөө нэгтгэх, хамтрах асуудалд судалгаанд оролцсон иргэд ач холбогдол өгч, санал нийлдэг тухайгаа илэрхийлж байлаа. Олон жилийн турш хууль бус гэж үзэн шахаж гадуурхдаг, үгүйсгэдэг нийгэм сэтгэл зүйн тогтсон хандлагыг өөрчлөхөд хувиараа алт олборлогч иргэдийн зохион байгуулалтын энэхүү хэлбэр чухал үүрэг гүйцэтгэж болох юм.

Хөгжлийн эхний шатанд бүрэлдэн тогтож, өөрийн хэв маягаа тодорхойлох үедээ оршин тогтнож буй эдгээр “нөхөрлөл”-үүдийг илүү нийгмийн хариуцлагатай, гишүүдийнхээ ирээдүйг баталгаажуулахад чиглэгдсэн бодлого, чиглэлтэй болж хөгжихөд мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгөх хэрэгцээ судалгааны туршид ажиглагдсан.

Хувиараа алт олборлогч иргэдийн байгуулсан нөхөрлөлүүдийн нийтлэг шинжийг дараахи байдлаар харуулъя.

1. Тохижилт - Нөхөрлөл тус бүр 1-2 гэр болон дотроо дулаалгатай модон амбаартай, 8-12 гишүүд зэрэгцэн унтахад зориулсан үргэлж ор нь амбаар болон гэрийн хойморт байрладаг. Зуух, гал тогтооны шүүгээ, ширмэн тогоо, гишүүдийн тоогоор шаазан аяга, халбага, сэрээ, дундаа 2-3 ширхэг гар нүүрийн алчуур, саван, 2-4 ширхэг явган сандал, гишүүний тоогоор хөнжилтэй
2. Ариун цэвэр – 14 нөхөрлөлийн зөвхөн 1 нь угаалтууртай. Нөхөрлөл бүр саван, гар нүүрийн алчууртай. Бүх гишүүд угаалга хийдэг дундаа 1 савтай. Өөр цэвэрлэх, ариутгах бодис, бүтээгдэхүүн ажиглагдаагүй. 2 нөхөрлөл нүхэн жорлонтой.
3. Хэрэглээ – Өдөрт 3 удаа хооллодог. Нөхөрлөл бүр тусдаа тогоочтой. Хоолны зэрэгцээ гамбир, боорцог идэж 2 удаа цай уудаг. Түлшиндээ мод хэрэглэдэг, цахилгаангүй, зөөврийн ус байхгүй. Өвлийн улиралд цас хайлуулж, бусад улирлуудад булгаас ус зөөдөг. Ном, сонин, телевиз, радио байхгүй, утасны сүлжээ барьдаггүй. Эмнэлэгийн яаралтай тусламжийн цүнх 4 нөхөрлөлд байх ба дотор нь спирт, бинт, гэдэсний эм байсан.
4. Байршил – Олборлолт хийдэг уул нь өндөр, уулын бэлээс нөхөрлөлүүдрүү хүрэх зам эгц, гулгаатай, нарийхан. Сумын төвөөс 30 км-ийн зайд байрладаг. Уулын бэлээс өгсөх, буухад ойролцоогоор 45-60 минут зарцуулдаг.
5. Харилцаа холбоо – Нөхөрлөлийн доторхи харилцаа холбоо нь хамтдаа хооллох, ажиллах, унтах зэргээр хязгаарлагддаг. Гишүүдийн хоорондын хувийн илтгэлцэл, ойлголцол, нэгдэл, нягтралыг дэмжих аливаа төрлийн үйл ажиллагаа, арга хэмжээ байдаггүй. Нөхөрлөл дотроо дарамт, хүчирхийлэл, стресс байхгүй. Бусад нөхөрлөлүүдтэй багаж, хэрэгслэлээ хуваалцах, цех хүртэл нийлж унаагаа зохицуулах, архидахаас өөр харилцаа холбоо байхгүй. Сумын төвөөс хүмүүсийг уулруу зөөх, хүнс хүргэх зорилгоор 2 машин байнга ирдэг. Хүдрээ тээрэмдүүлэхийн тулд сард 2-3 удаа уулнаас буудаг. Ээлжээр хүдрээ тээрэмдүүлнэ, энэ үедээ гэртээ харьж гэр бүлийнхээ уулздаг байна.

6. *Чөлөөт цаг* – Аль ч нөхөрлөлд ажлын цагийн хуваарь байхгүй. Хоолны цагаар, харанхуй болсон тохиолдолд гэсэн 2 нөхцөлд ажлаа зогсоодог. Чөлөөт цаг бага байгаа тухай гишүүд гомдолдоггүй. Өвөл болон хаврын улиралд цаг агаар эрс муудсан үед ажлаа зогсоож амардаг. Амарсан үедээ хөзөр тоглож, хоол идэж, архи ууж амардаг.
7. *Жендер* – Нөхөрлөлд 1-2 эмэгтэй ажилладаг. Тэд хоол хийх, цэвэрлэгээ хийх үүрэгтэй. Нөхөрлөлүүдийн арын албыг хариуцаж үлддэг. Эмэгтэйчүүдийг хүнд хөдөлмөр хийлгэхээр шахаж дарамталдаггүй, орлогоо тэнцвэртэй хуваадаг.

Кейс 8. Жендерийн асуудал

Хүснэгт 24. Кейс 8 – Жендерийн асуудал

Ярилцагч: Ц, 32 настай, эмэгтэй

Гэр бүлийн байдал: 2 хүүхэдтэй, өрх толгойлсон эмэгтэй


Ажил эрхлэлт: "Найрамдал" нөхөрлөлд тогооч

Энд 2009 оны 8 сард ирсэн, 2 хүүхэдтэй. Том охин нь ТМС-т сураад дотуур байранд амьдардаг, 2 настай хүү нь Борнуур сумын төвд ахынд нь байдаг. Сард 200,000-250,000 төгрөгийн цалин авдаг. Өдөрт 3 удаа хоол хийнэ. Ногоотой шөл, будаатай шөл, жигнэсэн гурилтай шөл, цуйван, ногоотой хуурга, гоймонтой хоол гэх мэт. Үүнээс гадна гамбир, боорцог, мантуу хийдэг. Гурил, будаа, гоймон, амтлагч, байцаа, төмс, лууванг сумаас татдаг. Нөхөрлөлийн ахлагч чанартай, арвин хоол хийж өгөхийг шаарддаг. Хүмүүс мод түлээг бэлдээд өгдөг учир хүнд хүчир ажил хийдэггүй. хувиараа алт олборлогч нар хүдэр олборлочихоод гарч ирэхдээ их өлссөн байдаг. Энэ үед нь халуун хоол цайтай байх үүрэгтэй. Нэг орохдоо 3 цаг гаруй болдог. Зарим хүмүүс нь амарч явчихаад ирдэггүй, тэгэхээр оронд нь өөр хүн ирдэг.

Энд ирснээс хойш ямар нэгэн эрүүл мэндийн сургалтанд хамрагдаж байгаагүй, сумын захиргаанаас хүн ирж байдалтай танилцаж байгаагүй. Өмнө нь хууль бусаар алт олборлодог байх үед янз бүрийн зүйл гардаг байсан гэсэн. Охид ирж хүдрээр биеэ үнэлэх, зодолдох гэх мэт. Одоо тийм явдал байхгүй. Миний хувьд энд аль болох удаан байж охиноо сургууль төгсгөх бодолтой, хүүгээ их санадаг. Амрахаараа ахындаа очиж гурил, будаа авч өгдөг. Энд эмэгтэй хүнийг ямар нэг байдлаар ялгаварлах, гадуурхах байдал ажиглагддаггүй.

Санал асуулгын судалгаанд оролцсон иргэдийн 42% нь ямар нэгэн нөхөрлөлд элсээгүй бөгөөд шалтгаанаа дараах байдлаар тайлбарлав.

Зураг 19. Нөхөрлөлд ордоггүй шалтгаан



Ганцаарчилсан болон гүнзгийрүүлсэн ярилцлагуудын явцад иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтанд эргэлзэх, хэн нэгэн хүний давуу эрх мэдэл, удирдлагад орохоос болгоомжилдог тухайгаа ярьж байсан. Олон жилийн турш хүнд хүчир ажил хийсэн, нийгмийн баталгаагүй орчинд ажиллаж амьдарсан, хамт олон, нэгдсэн удирдлаган дор ажиллах туршлага багатай зэрэг хүчин зүйлс тэднийг эргэлзэхэд хүргэсэн байж болох юм. Баг бүлгээр ажиллах хэрэгцээ, арга барил, ач холбогдлын талаарх мэдээлэл, зөвлөгөөг иргэдэд хүргэх хэрэгцээ “Сүжигтэй” ууланд алт олборлож буй иргэдэд нийтлэг ажиглагдаж байлаа.

Нөхөрлөлийн зохион байгуулалтын давуу талууд

- Гишүүдийн аюулгүй байдлыг хангах
- Хамт олонч, нийтэч сэтгэлгээг хөгжүүлэх
- Ажлын орчны тав тухтай байдлыг хангах
- Эмэгтэйчүүдийн оролцоо, хөдөлмөр хуваарилалтыг шударга зохион байгуулах
- Ажлын ачаалал, стрессийг хамтран үүрэх, нэгж гишүүнд ирэх дарамтыг хөнгөлөх
- Алт олборлох тэгш боломжийг гишүүдэд олгох
- Орд, амаа булаацалдах, зөрчилдөх шалтгаан багасгах
- Гишүүдийн гэр бүлийн стресс, түгшүүрийг багасгах
- Орон нутгийн иргэдийн хоорондын харилцаа, итгэлцэлийг нэмэгдүүлэх
- Алт олборлож буй хүн бүр орлогын албан татвар төлөх туршлагыг нэвтрүүлэх.
- Иргэдийн үйл ажиллагааг ажиглах, хянах, зохион байгуулахад хялбар болох
- Гишүүн бүр хөдөлмөрийн хөлсөө шударга, тэнцвэртэй хуваарилах нөхцөлөөр хангагдах зэрэг болно.

Нөхөрлөлийн зохион байгуулалтын сул талууд

- *Хүний хөгжлийн асуудлууд* – нийгэм сэтгэл зүйн хэрэгцээ, соёлын үйл ажиллагаа, өөрийн үнэлэмж, өөртөө итгэх итгэл, харилцаа холбоо, мэргэжил боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, хүүхдийн хүмүүжилд анхаарах зэрэг хүний хөгжлийн асуудлууд нь “нөхөрлөл”-үүдийн хувьд одоогийн байдлаар бүрэн орхигдож байна. Аливаа төрлийн бүлэг, байгууллага нь гишүүдийнхээ тогтвортой хөгжил, дэвшлийг хангахад анхаарлаа хандуулж тэр хэмжээгээрээ өөдлөн дэвждэг талаархи байгууллагын хөгжлийн ойлголт, удирдлагын

тогтолцоо, зарчим энэ орон нутагт огт ажиглагдсангүй. Гишүүдийнхээ зөвхөн биологийн болон эдийн засгийн хэрэгцээнд анхаарлаа хандуулж буй өнөөгийн байдал удаан үргэлжлэвэл үйл ажиллагааны хамрах хүрээ цаашид өргөжин тэлэх, нийгмийн хариуцлагатай хуулийн этгээд болж хөгжихөд хүндрэлтэй байж болох юм.


- *Амьдралын баталгаа* – энэ нэр томъёо нь “нөхөрлөл”-үүдийн хувьд зөвхөн найдвартай орон байр, хоол хүнс гэсэн ойлголтоор хязгаарлагдаж байна. Хөдөлмөрийн чадвараа алдах болон тэтгэврийн насанд хүрэх, цаашид эдийн засгийн тогвортой эх үүсвэртэй болох хамтын шийдлийг хайх, хэрэгжүүлэх буюу гишүүдийн ирээдүйн нийгэм, эдийн засгийн баталгааг хэрхэн хангаж болох талаар тодорхой бодлоготой байх, энэ асуудалд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай.
- *Илэн далангүй байдал* – хэдийгээр “нөхөрлөл”-үүд нь хөгжлийн эхний шатанд бүрэлдэн тогтож буй боловч орлого, зарлага, ажлын цагийн төлөвлөлт зэргийг гишүүддээ ижил мэдээлэх, ойлголцох нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай. Хувиараа ашигт малтмал олборлож буй бусад орон нутгуудын хувьд ч туршлага болж чадахуйц иргэдийн зохион байгуулалтын тус хэлбэрийг дэмжих, хөгжүүлэхэд онцгой анхаарах нь чухал юм.

7.2. БУХ ТББ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ ЧАНАР

БУХ ТББ нь Төв аймгийн Борнуур сумын Сүжигтэй ууланд хувиараа алт олборлож буй иргэдийг зохион байгуулалтанд оруулах, загвар бичил уурхайг үүсгэн хөгжүүлэх зорилгоор 2007 оны 11-р сард байгуулагдсан. Энэ зорилгын хүрээнд БУХ ТББ нь нийт гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, хүний эрүүл мэнд байгальд орчинд ээлтэй шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийн мөрдүүлж, гишүүдийнхээ бизнесийн үйл ажиллагааг дэмжих, тэдний нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг юм байна. Борнуур сумын 198 хувиараа алт олборлогч иргэд БУХ ТББ-д бүртгүүлэн үнэмлэх авсан бөгөөд 65 бүртгэгдээгүй нөхөрлөл байна.

Судалгаанд оролцсон иргэдийн 52%-нь ТББ-ын ажилтнууд болон удирдах зөвлөлийн гишүүдийн нэрийг мэдэх боловч байгууллагын нэр, зорилго, байршил болон үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэл байхгүй гэсэн хариултыг өгч байсан.

Зураг 20. ТББ-ын үйл ажиллагаа



ТББ-ын зүгээс хувиараа алт олборлогч иргэдэд чиглэгдсэн гол үйл ажиллагаа нь хурал уулзалт зохион байгуулах, эрх ашгийг нь хамгаалж нийтийн дуу хоолойг илэрхийлэх явдал гэж судалгаанд оролцсон хүмүүсийн 42% нь үзэж байсан бол тэдний 36% нь ТББ-ын үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэл өгч чадахгүй байсан юм.

Кейс 9.


Хүснэгт 25. Кейс 9

. . . хувиараа алт олборлодог хэн нэгэн хүн ямарваа нэгэн асуудлыг гаргаж тавихад хүн бүр нэг “нинжа” л ярьж байна гэж үздэг, үл хайхардаг явдал их байдаг. Гэтэл биднийг төлөөлөх бие даасан байгууллага гарч ирснээр хүмүүсийн хандлага, сонсох байдал нь хүртэл шал өөр болсон*.

Иргэн Х, 41 настай

ТББ-ын ажилтнууд, удирдах зөвлөлийн гишүүдтэй уулзаж Курт Левигийн аргачлалаар байгууллагын хөгжлийн түвшинг дараах байдлаар тодорхойлов.

Зураг 21. Байгууллагын хөгжлийг тодорхойлох нийгэм сэтгэл зүйн аргачлал



Фокус бүлгийн хэлэлцүүлгийн үед байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл, гарсан үр дүн, үр шим хүртсэн иргэдийн хүрээ, боловсон хүчний чадавхи, хөгжлийн асуудлууд гэсэн үндсэн 4 сэдвээр ярилцаж байгууллагын хөгжлийн түвшинг “Харилцаа холбоо тогтоох” үе буюу удирдлагын арга барилаа оновчтой сонгох, харилцаа холбоог хөгжүүлэхэд голлон анхаарч буй үе гэсэн дүгнэлтийг хийсэн.


Хөгжлийн энэ шатанд байгууллагын хэтийн төлөв, үнэт зүйл, эрхэм зорилго, дүрэм журам зэрэг дотоодын үзэл баримтлал /conception/ бүрэлдэн тогтож, эдгээр нь өдөр тутмын үйл ажиллагааг чиглүүлж удирдах үндсэн чиг шугам болж байдаг.

БУХ ТББ-ын ажил хэргийн архивт дараахь нэр, томъёотой хавтасуудыг он сарын дараалалаар байрлуулсан байлаа.

1. Сургалтын тэмдэглэл, хөтөлбөрүүд
2. Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл
3. Санал, хүсэлт
4. Холбооны бичиг баримтууд – хуулийн этгээд болохыг хууль зүйн яамнаас баталж олгосон гэрчилгээ, дансны хуулбар гэх мэт
5. Нөхөрлөлүүдийн бүртгэх
6. Техникийн дэд зөвлөл
7. Хяналтын зөвлөл
8. Нийгмийн дэд зөвлөл

Бичиг баримтуудын агуулгын давтамжийг дараахи зургаар илэрхийлэв.

Зураг 22. Баримт бичгүүдийн агуулга



Байгууллагын бичиг баримтуудыг судлахад өдөр тутмын үйл ажиллагаагаа нэг бүрчлэн тэмдэглэж баталгаажуулсан, жил бүрийн төлөвлөгөө нь үйл ажиллагаа, шаардагдах зардал, хэмжих шалгуур үзүүлэлтүүдтэй байсан нь жилийн эцэст ажлаа үнэлэн дүгнэхэд хялбар байдаг зэрэг давуу талууд ажиглагдсан.

ТББ-ын ажилтнууд болон удирдах зөвлөлийн гишүүдтэй хийсэн ярилцлага, уулзалтын дүнд байгууллагыг илүү хурдацтай хөгжүүлэх, дэмжихэд анхаарах дараах асуудлуудыг тодорхойлсон.

- о Байгууллагын хэтийн төлөв, хүрэх үр дүн, төлөвлөгөөг илүү тодорхой, гишүүн бүрт ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар тодорхойлох, сурталчилах
- о Зөвлөлүүдийн үйл ажиллагаа, шийдвэр төлөвлөлтүүдийн харилцан хамаарал, логик холбоог сайжруулах.

ТББ нь иргэний нийгмийн байгууллагын нэгэн хэлбэр болохын хувьд нийгмийн харилцаагаа хөгжүүлэх, үйл ажиллагаандаа хамрагдах боломжийг зорилтот бүлгүүдэд тэгш олгох, сонирхогч талуудад тогтмол хугацаанд мэдээлэл түгээх, боловсон хүчнийг хөгжүүлэх, бэлтгэх асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай. Байгууллагын үндсэн гурван зорилт тус бүрээр ойрын 3, 5, 10 жилийн хугацаанд ямар ахиц гаргах, өөрчлөлтүүдийг хийх талаар илүү тодорхой төлөвлөж ажиллах нь хөгжлийг хурдасгах үндсэн түлхэц байж болох юм.

БУХ ТББ-аас зохион байгуулсан хурал, уулзалтуудын тэмдэглэлүүд болон зөвлөлийн гишүүдтэй хийсэн уулзалтаас дүгнэхэд тодорхой шийдвэр гаргах зорилготой уулзалт, хуралд хувиараа алт олборлогч компанийн ажилтнууд олонхийн байр суурийг эзэлж өөрсдийн үзэл, хандлагаар асуудалд хандах, шийдвэр гаргахад массаараа нөлөөлөх байдал ажиглагдаж байсан.

Төрийн бус байгууллагын тодорхойлсноор тус хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн төрийн бус байгууллагын бүтэц, зохион байгуулалт, шийдвэр гаргалтад оролцох байдал дараах байдалтай байлаа.

Зураг 23. ТББ-ын Удирдлага зохион байгуулалт




Хувиараа алт олборлогч иргэдийн зохион байгуулалт, нэгдмэл хэрэгцээ, асуудлуудыг үндэслэн байгуулагдсан БУХ ТББ-ын мөн чанар, онцлог нь төрийн бус байгууллагын статусаас илүү олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагын /community based organization/ хэлбэрээр оршин тогтнох нь тогтвортой байдлыг хангах, нийтийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах таатай нөхцөлийг бүрдүүлэх боломжтой юм.

Олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагын зохион байгуулалтын үндсэн зарчим нь “нэгж гишүүнээс нэгж санал” буюу тодорхой шийдвэрийг гаргахад гишүүн бүрийн саналыг олон төрлийн арга хэлбэрээр судлах, тусгах, цөөнхийг эрх, эрх чөлөөг хүндэтгэн, олонхийн саналаар шийдвэр гаргах тогтолцоо юм.

Хуралд гишүүд оролцсон эсэхээс үл шалтгаалан тэдний саналыг аль болох тэнцвэртэй сонсох, тусгах асуудалд энэ төрлийн байгууллагууд чухал ач холбогдол өгдөг.

Хэдийгээр манай орны хувьд олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагын харилцаа, үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин, нөхцөл бүрдээгүй боловч БУХ ТББ-ын зүгээс дээрхи байгууллагын хэлбэрийн мөн чанар, ардчилсан хандлагыг баримтлах, ашиглах шаардлага ажиглагдаж байна.



БҮЛЭГ 8.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ДҮГНЭЛТҮҮД

Төв аймгийн Борнуур сумын нийгэм, эдийн засгийн суурь судалгааны үр дүн дээр үндэслэн судалгааны багийн зүгээс дараах дүгнэлтийг хийж байна.

Бүлэг 2.

Борнуур сумын хүн ам зүй, нийгэм эдийн засаг, ашигт малтмал олборлолтын байдал

- “Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” батлагдснаар хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхлэх анхны эрх зүйн орчин бүрдэж, орон нутгийн засаг захиргааны зүгээс энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэдэд хандах хандлага өөрчлөгдөн, анхаарал тавьж эхэлснийг иргэд талархалтайгаар хүлээн авч байгаа нь харагдаж байлаа.
- Үйлдвэрлэл, үйлчилгээний салбар сайн хөгжөөгүй учраас орон нутгийн хэмжээнд ажлын байр ховор, хөдөлмөрийн зах зээлийн хүрээ харьцангуй хязгаарлагдмал байна.
- Байгалийн нөөцийг ашиглах үйл ажиллагаа нь эдийн засгийн үндсэн эх үүсвэр гэж тооцогддог.
- Хүн амын 70 орчим хувь нь алт олборлолтоор амьжиргаагаа залгуулдаг ба улирлын чанартайгаар газар тариалан эрхлэх хандлага байна. Харин залуучуудын хувьд биеийн хүчний ажил эрхлэх боломжтой учир хувиараа алт олборлогч иргэдийн бүртгэгдээгүй нөхөрлөлд элсэн алт олборлох, өндөр настнууд болон эмэгтэйчүүлийн “аргал түүх” буюу нөхөрлөлүүдийн олборлож үлдсэн хүдрийг түүх байдлаар амьжиргаагаа залгуулдаг.
- Борнуур сумын нийт хувиараа алт олборлогч иргэдийн 68 орчим хувь нь эрэгтэй, 32 орчим хувь нь эмэгтэй хүмүүс байдаг.

Бүлэг -3

Борнуур сумын хувиараа алт олборлогч иргэдийн нийгэм эдийн засгийн байдал

- Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэд тухайн орон нутагт бүртгэлтэй болж, эрүүл мэнд болон нийгмийн даатгалд хамрагдсанаар төрийн халамж, үйлчилгээ хүртэх, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх боломж бүрдэж эхэлсэн байна.

- Сүжигтэй ууланд хувиараа алт олборлож буй иргэдийн сарын дундаж орлогын хэмжээ нь Төв аймгийн албан ёсоор ажил эрхлэгч иргэдийн сарын дундаж цалингаас 1,3 дахин их буюу дунджаар 360,000 төгрөг байна. Ер нь тэдний орлого нь алтны судал, гарц, тэдний ажилласан хугацаа, дадлага, туршлага, ур чадвар, тоног төхөөрөмж багаж хэрэгслийн хүчин чадал зэргээс шалтгаалж байгаа ба дийлэнх иргэд олсон алтаа хувиараа алт олборлогч ХК-д газар дээр нь тушааж
- Тэдний хувьд алт олборлох үед хамгийн түрүүнд тохиолддог бэрхшээл нь ус, цахилгаан, гэр оронтой байхаас илүүтэйгээр дарагдах, нурах, осол гэмтлээс айх, түгшүүртэй байдал гэж үзэж байгаа нь байр, хоол, хувцас зэрэг хүний суурь хэрэгцээнээс илүүтэйгээр сэтгэлзүйн бэрхшээл давамгайлж байна.
- *Амьдралын баталгаа* – энэ нэр томъёо нь “нөхөрлөл”-үүдийн хувьд зөвхөн найдвартай орон байр, хоол хүнс гэсэн ойлголтоор хязгаарлагдаж байна. Хөдөлмөрийн чадвараа алдах болон тэтгэврийн насанд хүрэх, цаашид эдийн засгийн тогвортой эх үүсвэртэй болох хамтын шийдлийг хайх, хэрэгжүүлэх буюу гишүүдийн ирээдүйн нийгэм, эдийн засгийн баталгааг хэрхэн хангаж болох талаар тодорхой бодлоготой байх, энэ асуудалд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай.
- *Илэн далангүй байдал* – хэдийгээр “нөхөрлөл”-үүд нь хөгжлийн эхний шатанд бүрэлдэн тогтож буй боловч орлого, зарлага, ажлын цагийн төлөвлөлт зэргийг гишүүддээ ижил мэдээлэх, ойлголцох нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай. Хувиараа ашигт малтмал олборлож буй бусад орон нутгуудын хувьд ч туршлага болж чадахуйц иргэдийн зохион байгуулалтын тус хэлбэрийг дэмжих, хөгжүүлэхэд онцгой анхаарах нь чухал юм.

Бүлэг -4

Хувиараа алт олборлогч нарын алт олборлолтын орлого ба зарлага

- Алт олборлодог иргэдийн сарын дундаж орлого нь МУ-ын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 42,000 – 380,000 төгрөгөөр илүү байдаг болохыг санал асуулгын судалгаагаар тодорхойлсон.
- Хувиараа алт олборлогч иргэд орлогоо тодорхойлоход нилээд удаан бодох, хариулахаас татгалзах байдал олон тохиолдсон бөгөөд энэ нь нэг талаас “цагаан хэл эм” хүрэх магадлалтай гэсэн уламжлалт сэтгэлгээ, нөгөө талаас орлогоо хянах, зохицуулах, төлөвлөх хандлага, боловсрол багатай холбоотой байж болох юм.
- Хувиараа алт олборлогч иргэдийн алт олборлоход зарцуулдаг зардал нь бөөнөөр худалдан авсан хүнсний хэрэглээнд харьцангуй өндөр гарсан. Энэ байдал нь хүйтэн, хүнд нөхцөлд ажилладаг учраас илчлэг сайтай хүнс тэжээл хэрэглэх биологийн хэрэгцээтэй холбоотой байж

болох ч нөгөө талаас тансаг хэрэглээг эрхэмлэх, олсоноо үрэх зуршил, хандлагын нөлөөлөл байж болох юм.

Бүлэг 5:

Алт олборлолт буюу ажил эрхлэлтийн байдал

- Төв аймгийн Борнуур суманд хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн алтны үндсэн ордоос олборлосон хүдрийг баяжуулах боловсруулах цех байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлсэн нь Монгол улсад бичил уурхайн салбарыг хөгжүүлэх томоохон эхлэл юм.
- Тэдний алт олборлох ажлыг эрхлэх болсон шалтгаанд хүүхдийн сургалтын төлбөр, өр зээлээ төлөх, орон байртай болох, эмчилгээний зардал олох бөгөөд хамгийн шол шалтгаан нь ажил олдохгүйгээс амьжиргаа залгуулах эх үүсвэр болж байгаа гэсэн байна.
- Хувиараа алт олборлогч иргэд давчуу харанхуй хүйтэн тохиромжгүй нөхцөлд ажиллаж, биеийн хүчний хүнд ажлыг хийдэг бөгөөд нэг маягийн хөдөлгөөний давталт ихтэй, биеийн тохиромжгүй, албадмал байрлалд, давчуу зайнд ажилладаг, халтирах, тээглэх унах, юманд цохиулах, даруулах, иртэй болон хөдөлгөөнтэй багаж хэрэгсэлтэй харьцах үед хавчуулагдах, зүсэгдэх зэрэг осол гэмтэлд өртөх эрсдэл өндөртэй байна.
- Тэдгээр иргэд зориулалтын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хувцас хэрэглэл хэрэглэдэггүй, өөрсдийн өдөр тутам өмсдөг ердийн гутал, ажлын хувцастайгаа ажилладаг бөгөөд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны багаж хэрэгсэл, хувцсыг сонгох, хэрэглэх мэдлэг хандлага хангалтгүй байна.
- Хувиараа алт олборлож буй иргэд дунджаар 9 цаг ажиллан ажлын өдрийн цаг, завсарлага, долоо хоногийн амралтын өдөр зэрэг нь алтны олдоц, улирлын байдал, цаг агаар зэргээс хамаардаг бөгөөд тэдэнд баримтлах хөдөлмөр амралтын тогтсон горим байдаггүй.

Бүлэг 6:

Хувиараа алт олборлогч иргэлийн эрүүл мэндийн байдал ба эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

- Ажлын орчинд эрүүл ахуйн наад захын шаардлага хангах байдал дутмаг байхын зэрэгцээ хүнд хортой нөхцөлд удаан ажилласны дараа хэрэглэх сүү, цагаан идээ, амин дэмийн хангалт, хэрэглээ бага байсан.
- Дур мэдэн витамин авч уух, өвдсөн үедээ эмчийн зөвлөгөөгүйгээр антибиотек авч хэрэглэх, ахуйн аргаар өвчнөө эмчлэх, бүрэн гүйцэд эдгээхгүй хаях зэрэг асуудлууд гарч байна.

- Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, анхаарах орчин нөхцөл хувиараа алт олборлогч иргэдийн ажил, амьдралын орчинд тун бага. Хүнд өвдсөн, гарцаагүй тусламж шаардлагатай үед эмнэлэгт хандаж байна.
- Хувиараа алт олборлогсдын ажлын байрны тоос, шуугиан, доргион эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа нь ажилчид тоосны гаралтай уушиг тоосжих, шуугианы гаралтай сонсгол муудах, дүлийрэх, бөөр нуруу, яс булчин хөдөлгөөний тулгуур эрхтний эмгэг үүсэх эрсдэлтэй байна.
- Алт олборлогсдын тал хувь нь гэнэтийн, яаралтай тохиолдолд эмнэлгийн тусламжийг 3 цагийн дотор авах боломжгүй гэж хариулж байсан. Эрүүл мэндийн тусламж авахад гардаг гол бэрхшээлд тэднийг хаяг тодорхойгүй, алслагдмал байдал, тээврийн хэрэгсэл дутмаг, холбоо харилцаа байхгүй зэрэг орж байна. Тэдэнд баталгаат, зайлшгүй шаардлагатай эмийн үйлчилгээ, эмчийн үзлэг, оношлогоо, нарийн мэргэжлийн үзлэг, осол гэмтлээс сэргийлэх, өвчнөөс сэргийлэх мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ шаардлагатай байна.

Бүлэг 7:

Хувиараа алт олборлогч иргэлийн зохион байгуулалт хамтын ажиллагаа

- БУХ ТББ-ийн зохион байгуулалтын тусламжтайгаар нийт 198 ХАМО иргэн 68 бүртгэгдээгүй нөхөрлөлд орж зохион байгуулалт орсон байна.
- Нөхөрлөл, ТББ нь хувиараа алт олборлогч иргэдийн ажлын орчин дахь аюулгүй ажиллагаа, хамгаалалтанд анхаарал хандуулах байдал харьцангуй бага.
- Орон нутгийнхаа байгалийн баялаг, нөөцийг ашиглаж байгаагийн төлөө тодорхой хариуцлага хүлээх, байгаль орчноо нөхөн сэргээх, хамгаалах болон нийгмийн салбарт хөрөнгө оруулалт хийх санаачлага гарч эхний үйлдлүүдээ хийж эхлэсэн.
- *Хүний хөгжлийн асуудлууд* – нийгэм сэтгэл зүйн хэрэгцээ, соёлын үйл ажиллагаа, өөрийн үнэлэмж, өөртөө итгэх итгэл, харилцаа холбоо, мэргэжил боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, хүүхдийн хүмүүжилд анхаарах зэрэг хүний хөгжлийн асуудлууд нь “нөхөрлөл”-үүдийн хувьд одоогийн байдлаар бүрэн орхигдож байна. Аливаа төрлийн бүлэг, байгууллага нь гишүүдийнхээ тогтвортой хөгжил, дэвшлийг хангахад анхаарлаа хандуулж тэр хэмжээгээрээ өөдлөн дэвждэг талаархи байгууллагын хөгжлийн ойлголт, удирдлагын тогтолцоо, зарчим энэ орон нутагт огт ажиглагдсангүй. Гишүүдийнхээ зөвхөн биологийн болон эдийн засгийн хэрэгцээнд анхаарлаа хандуулж буй өнөөгийн байдал удаан үргэлжлэвэл үйл ажиллагааны хамрах хүрээ цаашид өргөжин тэлэх, нийгмийн

хариуцлагатай хуулийн этгээд болж хөгжихөд хүндрэлтэй байж болох юм.

ЗӨВЛӨМЖ

Хувиараа алт олборлогч иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал, нийгмийн халамж үйлчилгээний хүртээмж, хэрэгцээг судлах ажлын үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг толилуулж байна. Үүнд:

- Бичил уурхайн хуулийг яаралтай батлан гаргах шаардлагатай байгаа бөгөөд хуулийн төслийг боловсруулахдаа ХАМО иргэдийн хэрэгцээ, шаардлага, бодол зөвлөмжийг сайтар тусгах хэрэгтэй
- Орон нутгийн тусгай хэрэгцээнд ашигт малтмалын нөөц бүхий газрыг шилжүүлэх, мөн орон нутгийн удирдлагад олборлолтын газар олгох эрхийг өгөх замаар ХАМО иргэдийн газрын асуудлыг шийдэх боломжийг судлах
- Бичил уурхайн хууль эрх зүйн зохицуулалтын талаар бусад орнуудын туршлага, сургамжаас суралцах
- ТоБУТ нь бодлого, зохицуулалтын орчны хувьд ямар хэмжээ/юунд хүрсэн байх хэтийн зорилго, төлөв байдлаа тодорхойлох хэрэгтэй.
- Хувиараа алт олборлогчдын тухай мэдээллийг тухайн орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан жил тутам гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн асуудал, хөдөлмөрийн зах зээлийн албан бус хэвшил дэх тэдний үүрэг, оролцоог тодорхойлж байх, бодлого боловсруулагч, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах
- Хувиараа алт олборлогчдын эрхэлж буй үйл ажиллагаа нь хөдөлмөр зарцуулалт ихтэйг анхааран тэднийг энгийн, хямд төсөр, ашиглаж болохуйц техник, тоног төхөөрөмжтэй болоход туслах, үүнийг бичил санхүүгийн харилцаа буюу жижиг зээл, түрээсээр дамжуулан хэрэгжүүлэх
- Орон нутгийн түвшинд алт худалдах, худалдан авах журмыг боловсруулах
- Сүжигтэй ууланд төвлөрсөн бие засах газар, нэгдсэн хогийн цэгүүлийг болгох зэргээр орчны эрүүл ахуйг сайжруулж болзошүй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах
- Олборлолт хийж буй газар ундны усны хангамжийг сайжруулах, баталгаагүй ус хэрэглэхгүй байх талаар зөвлөгөө, зөвлөмж өгөх, дорвитой ажил хийх хэрэгтэй байна
- Хувиараа алт олборлогчдын эрхэлж буй үйл ажиллагааны аюултай, эрсдэлтэй, эрүүл мэндэд сөрөг нөлөөлтэй байдлыг харгалзан тэднийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд хоёроос доошгүй удаа хамруулж, тогтмолжуулах

- Хувиараа алт олборлогчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг, хандлага, дадал туршлага хангалтгүй байгааг анхааран энэ талаарх сургалт, сурталчилгаа, мэргэжлийн тусламж, үйлчилгээ, зөвлөгөө өгөх ажлыг мэргэжлийн байгууллага, сайн дурынхнаар дамжуулан зохион байгуулах,
- Хувиараа алт олборлогчдын хууль бус тэсэлгээний асуудлыг шийдвэрлэх арга замыг судлах, гарцыг яаралтай тодорхойлох
- Хувиараа алт олборлогчдыг нийгмийн даатгал, нийгмийн халамжийн суурь үйлчилгээнд бүрэн хамруулах арга хэмжээ авах
- Хувиараа алт олборлогчдын бие хүний хувьд хөгжих боломж хязгаарлагдмал, хүмүүс хоорондын харилцаа сул, доголдолтой байдгаас сэтгэлээр унах, айж эмээх, сэтгэл санаа тавгүйтэх зэрэг үзэгдэл түгээмэл байдаг тул тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх,
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, бүтээмж өндөртэй, гар багаж хэрэгсэл тоног төхөөрөмжийн загварыг боловсруулан олборлолтын үйл ажиллагаанд нь нэвтрүүлэх
- ХАМО нарын эрх ашгийг хамгаалан ажиллаж байгаа ТББ-ын үйл ажиллагааг дэмжин цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах боломж бололцоогоор хангаж ажиллах
- Нөхөрлөлийн гишүүд буюу ТББ-ын гишүүдийг идэвхжүүлэх, эрх ашгийг хамгаалан ажилладаг байгуулагатайгаа хамтран өөрсдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцдог болгох хандлагыг суулгах ажлуудыг зохион байгуулах



ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1

АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, Үндэсний Статистикийн газар, УБ хот, 2008 он
2. Төв аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн мэдээлэл, Аймгийн Статистикийн алба, Зуунмод, 2009 он
3. Socio-economic situation of informal gold miners in Mongolia (survey report), joint: UNFPA, Government of Japan, School of public health, health sciences university of Mongolia; UB, 2007
4. Informal gold mining in Mongolia, International Labor office, UB, 2006
5. Бичил уурхай, хэтийн төлөв, зохицуулалт, ТоБУ төсөл, ШХА, УБ, 2008
6. Blue Sky Mining: community and mining in Omnogovi aimag, Pact Mongolia, UB, 2008
7. Artisanal and Small-scale mining in Mongolia, research paper 4, J.Janzen and others, UB, 2007
8. Олон улсын туршлагаас товч танилцуулах нь, М. Приестэр (орчуулга), ШХА, УБ, 2005
9. Монголын хувиараа ашигт малтмал олборлогчдын техник, технологийн үнэлгээ, ТоБУ төсөл, ШХА, УБ, 2007
10. Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, заавар, ТоБУ төсөл, ШХА, УБ, 2009
11. Нинжа нарын нэн шинэ түүх, ТоБУ төсөл, ШХА, УБ, 2009
12. “Бичил уурхай ба хөдөөгийн хөгжил” үндэсний зөвлөгөөн, ТоБУ, ШХА, УБ, 2009

ХАВСРАЛТ 2

ХАМО иргэдээс авах санал асуулга

БОРНУУР СУМАНД ХИЙХ СУУРЬ СУДАЛГААНЫ АСУУМЖ

	Ярилцлага авсан огноо	
	Судалгаанд хариулагчийн дугаар	
	Судлаачийн дугаар	
	Асуулга авсан багийн нэр	
1-р хэсэг: Ерөнхий мэдээлэл		
101	Таны хүйс	
102	Та хэдэн настай вэ?	
103	Таны ам бүлийн тоо?	
104	Та хэдэн хүүхэдтэй вэ?	
105	Та бичиг үсэг мэддэг үү?	
106	Та ямар боловсролтой вэ?	
	Боловсролгүй	<u>A</u>
	Бага боловсролтой	<u>B</u>
	Бүрэн бус дунд боловсролтой	<u>C</u>
	Бүрэн дунд боловсролтой	<u>D</u>
	Тусгай дунд	<u>E</u>
	Дээд	<u>F</u>
107	Таны гэрлэлтийн байдал	
	Гэрлэсэн	<u>A</u>
	Салсан	<u>B</u>
	Ганц бие	<u>C</u>
	Хамтран амьдардаг	<u>D</u>
	Бэлэвсэн	<u>E</u>
2-р хэсэг: Өрхийн амьжиргааны байдал		
201	Танай гэр бүлийн орон сууцны байдал?	
	Өөрийн гэрт	<u>A</u>
	Өөрийн байшинд	<u>B</u>
	Түрээсийн гэрт	<u>C</u>
	Түрээсийн байшинд	<u>D</u>
	Нийтийн байранд	<u>E</u>
	Эцэг эхийн гэрт	<u>F</u>
	Орон сууцанд	<u>G</u>
	бусад	<u>H</u>
202	Та ажил хөдөлмөр эрхэлж, сурдаг уу?	
	Тийм <u>A</u>	<u>A</u>
	Үгүй <u>B</u>	<u>B</u>
203	Тийм бол хаана ажиллаж, сурдаг вэ?	

	Төрийн байгууллагад	<u>A</u>
	Төрийн бус байгууллагад	<u>B</u>
	Хувийн компанид	<u>C</u>
	Хувиараа МАА эрхэлдэг	<u>D</u>
	Наймаа худалдаа	<u>E</u>
	Их дээд сургууль	<u>F</u>
	Коллеж, МСҮТ	<u>G</u>
	ХАМО	<u>H</u>
	бусад	<u>I</u>
204	Та өрхийнхөө сарын орлогыг тодорхойлно уу?	
a	Орлогын эх үүсвэр	Сар Жил
b	Цалин	
c	Тэтгэвэр	
d	Тэтгэмж	
e	Наймаа	
f	Газар тариалан	
g	Мал аж ахуй	
h	Туслах аж ахуй	
i	Зээл тусламж	
l	Ах дүү, төрөл садангийн тусламж	
m	Эд хөрөнгө түрээслэсний орлого	
n	Алтны олборлолт	
o	Бусад	
	Нийт	204.a 204.б
205	Танай өрхийн нэг хүнд оногдох сарын/ жилийн орлого хэд вэ?	
	205.a	
	205.б	
206	Та хувьдаа өөрөө явагч тээврийн хэрэгсэлтэй юу?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
207	Танай өрх сардаа хэдэн төгрөг хадгалж чаддаг вэ?	
	0	<u>A</u>
	100000 хүртэл	<u>B</u>
	500000 хүртэл	<u>C</u>
	1 сая хүртэл	<u>D</u>
	1 саяас дээш	<u>E</u>
3-р хэсэг: Орон нутгийн харъяалал, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл		
301	Та энэ орон нутагт хэдэн жил ажиллаж байна вэ?	
	Уугуул оршин суугч	<u>A</u>
	3-аас дээш жил амьдарч байгаа	<u>B</u>
	1-3 жил амьдарч байгаа	<u>C</u>
	1 хүртэл жил ажиллаж байгаа	<u>D</u>

302	Хэрэв та энд 1 хүртэл жил амьдарч байгаа бол та сумандаа албан ёсоор бүртгүүлсэн үү?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
303	Хэрэв үгүй бол яагаад?	
	Бүртгүүлэх шаардлагагүй гэж бодсон	<u>A</u>
	Энэ талаар тодорхой мэдээлэл байхгүй	<u>B</u>
	Иргэний үнэмлэх байхгүй	<u>D</u>
	Бусад холбогдох бичиг баримт байхгүй	<u>E</u>
	Хаашаа хэнд хандахаа мэддэггүй	<u>F</u>
	Ажил ихтэй завгүй байдаг	<u>G</u>
	Шилжүүлэг хийлгэх мөнгө байхгүй	<u>H</u>
304	Та ер нь ямар тохиолдолд бүртгүүлэх шаардлагатай гэж үзэж байна вэ?	
	Эрүүл мэндийн яаралтай тусламж авах	<u>A</u>
	Нийгмийн халамж үйлчилгээ авах	<u>B</u>
	Эмнэлэгт үзүүлэх	<u>C</u>
	Хүүхдээ сургууль, цэцэрлэгт оруулах	<u>D</u>
	Бусад	<u>E</u>
305	Таны Борнуурт шилжин ирж амьдрах болсон шалтгаан юу вэ?	
	Алт олборлох	<u>A</u>
	Газар тариалан эрхлэх	<u>B</u>
	Бэлчээр хайх	<u>C</u>
	Ах дүү нараа бараадах	<u>D</u>
	Илүү сайн сургууль үйлчилгээ хайх	<u>E</u>
	Ажиллах боломж хайх	<u>F</u>
	Хүдэр баяжуулах цехтэй учир	<u>G</u>
4-р хэсэг: Алт олборлолт буюу ажил эрхлэлтийн байдал		
401	Та хэдэн жил алт олборлож байгаа вэ?	
402	Та яагаад алт олборлох болсон бэ?	
	Суманд ажлын байр байхгүйгээс	<u>A</u>
	Малаа зуданд алдсан	<u>B</u>
	Амьжиргаагаа залгуулахын тулд, өөр орлого олох боломж бага	<u>C</u>
	Хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөх	<u>D</u>
	Алт олборлолт өндөр орлоготой учраас	<u>E</u>
403	Та одоогоор ямар ямар газруудад алт олборлож байна вэ?	
	а.	
	б.	
404	Та өөрийгөө ашигт малтмал олборлох зөвшөөрөлтэй газар ажилладаг гэж үздэг үү?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
405	Та цаашид алт олборлох ажлаа эрхэлсээр байх уу?	

	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
а	Тийм бол яагаад?	
б	Үгүй бол яагаад?	
406	Та алт олборлолтын ажлыг хэр тогтвортой эрхэлдэг вэ?	
	байнга	<u>A</u>
	улирлын чанартай	<u>B</u>
	амралт чөлөөт цагаараа	<u>C</u>
407	Та жилийн аль улиралд алт олборлолтыг илүү ихээр хийдэг вэ?	
	Хавар	<u>A</u>
	Зун	<u>B</u>
	Намар	<u>C</u>
	Өвөл	<u>D</u>
408	Та хоногт дунджаар хэдэн цаг ажилладаг вэ?	
409	Үүнээс хэдэн цагт нь газар дор ажилладаг вэ?	
410	Та ажиллах үедээ эдгээр хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслүүдээс хэрэглэдэг үү?	
	Каск	<u>A</u>
	Бээлий	<u>B</u>
	Маск	<u>C</u>
	Ажлын гутал	<u>D</u>
	Чихний бөглөөс	<u>E</u>
	Комбинзон	<u>F</u>
	Бэхлэгч	<u>G</u>
	Бэхэлгээний олс	<u>H</u>
	Толгойн гэрэл	<u>I</u>
	Усны гутал	<u>L</u>
	Хамгаалах нүдний шил	<u>M</u>
	Бусад	<u>N</u>
411	Эдгээр хувцас хэрэглэлүүдээс хамгийн хэрэгтэй нь юу вэ?	
	Каск	<u>A</u>
	Бээлий	<u>B</u>
	Маск	<u>C</u>
	Ажлын гутал	<u>D</u>
	Чихний бөглөөс	<u>E</u>
	Комбинзон	<u>F</u>
	Бэхлэгч	<u>G</u>
	Бэхэлгээний олс	<u>H</u>
	Толгойн гэрэл	<u>I</u>
	Усны гутал	<u>L</u>
	Хамгаалах нүдний шил	<u>M</u>
	Бусад	<u>N</u>
412	Та ямар хөдөлмөрийн багаж хэрэгслүүдийг хэрэглэдэг вэ?	
	Хүрз	<u>A</u>
	Жоотуу	<u>B</u>

	Лоом	<u>C</u>
	Сков	<u>D</u>
	Лебёдик	<u>E</u>
	Шат	<u>F</u>
	Зөөврийн гэрэл	<u>G</u>
	Алх, лантуу	<u>H</u>
	Тэсэлгээний бодис хадгалах сав	<u>I</u>
	Анхны тусламжийн хайрцаг	<u>L</u>
	Агаар хэмжигч	<u>M</u>
	Олс	<u>N</u>
	Шуудай	<u>O</u>
	Шигшүүр	<u>P</u>
	Уур, нүдүүр	<u>Q</u>
	Тээрэм	<u>R</u>
	Сэнс	<u>S</u>
	Компрессор, цохилтот өрөм	<u>T</u>
	Бусад	<u>U</u>
413	Эдгээр хөдлөлмөрийн багаж хэрэгслээс хамгийн их ажил хөнгөвчилдөг багаж нь юу вэ?	
	Хүрз	<u>A</u>
	Жоотуу	<u>B</u>
	Лоом	<u>C</u>
	Сков	<u>D</u>
	Лебёдик	<u>E</u>
	шат	<u>F</u>
	Зөөврийн гэрэл	<u>G</u>
	Алх, лантуу	<u>H</u>
	Тэсэлгээний бодис хадгалах сав	<u>I</u>
	Анхны тусламжийн хайрцаг	<u>L</u>
	Агаар хэмжигч	<u>M</u>
	Олс	<u>N</u>
	Шуудай	<u>O</u>
	Шигшүүр	<u>P</u>
	Уур, нүдүүр	<u>Q</u>
	Тээрэм	<u>R</u>
	Сэнс	<u>S</u>
	Компрессор, цохилтот өрөм	<u>T</u>
	Бусад	<u>U</u>
414	Таньд хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл хэрэглэхтэй холбоотой ямар хүндрэл гардаг вэ?	
	Хэрэглэх хүсэл, сонирхолгүй	<u>A</u>
	Ямар хувцас, хэрэгсэл хэрэглэхээ мэддэггүй	<u>B</u>
	Энэ талаар мэдээлэл авах боломжгүй	<u>C</u>
	Үнэ өндөр	<u>D</u>
	Хэрэглэхэд тохиромжгүй, хүндрэлтэй	<u>E</u>
	Олддоггүй	<u>F</u>

	Бусад	<u>G</u>
415	Та алт олборлохдоо ямар төрлийн ажил хийдэг вэ?	
	Чулуу бутлах	<u>A</u>
	Тэсэлгээ хийх	<u>B</u>
	Шороо зөөх, шигших	<u>C</u>
	Хүдрээ тээрэмдэх	<u>D</u>
	Мөнгөн усаар бариулах	<u>E</u>
	Олборлосон хүдрээ цех рүү зөөх	<u>F</u>
	Бусад	<u>G</u>
416	Та өдөрт/ долоо хоногт дунджаар хэдэн шуудай хүдэр олборлодог вэ?	
417	Үндсэн ордын хувьд эдгээр ажлуудаас эмэгтэйчүүд ямар ажлыг голдуу хийдэг вэ?	
	Чулуу гар багажаар бутлах	<u>A</u>
	Чулуу хад компрессороор бутлах	<u>B</u>
	Тэсэлгээ хийх	<u>C</u>
	Уур нүдүүрээр нунтаглах	<u>D</u>
	Хүдрээ тээрэмдэх	<u>E</u>
	Мөнгөн усаар бариулах	<u>F</u>
	Тунел доор хаягдсан хүдрүүдийг түүх	<u>G</u>
	Олборлосон хүдрээ цех рүү зөөх	<u>H</u>
	Орчны цэвэрлэгээ	<u>I</u>
	Угаалга цэвэрлэгээ хийх	<u>L</u>
	Хоол цай хийх	<u>M</u>
	Бусад	<u>N</u>
418	Доорхи ажлуудаас хамгийн хэцүү нь юу вэ?	
	Чулуу гар багажаар бутлах	<u>A</u>
	Чулуу хад компрессороор бутлах	<u>B</u>
	Тэсэлгээ хийх	<u>C</u>
	Уур нүдүүрээр нунтаглах	<u>D</u>
	Хүдрээ тээрэмдэх	<u>E</u>
	Мөнгөн усаар бариулах	<u>F</u>
	Тунел доор хаягдсан хүдрүүдийг түүх	<u>G</u>
	Олборлосон хүдрээ цех рүү зөөх	<u>H</u>
	Орчны цэвэрлэгээ	<u>I</u>
	Угаалга цэвэрлэгээ хийх	<u>L</u>
	Хоол цай хийх	<u>M</u>
	Бусад	<u>N</u>
419	Танд ажлын нөхцөл байдлуудаас хамгийн хүнд бэрхшээлтэй нь юу вэ?	
	Тоос шороо	<u>A</u>
	Ус чийгтэй харанхуй байдал	<u>B</u>
	Хэт хүйтэн	<u>C</u>
	Дуу шуугиан	<u>D</u>
	Харанхуй	<u>E</u>
	Агааргүй	<u>F</u>
	Химийн бодистой харьцах	<u>G</u>

	Удаан хугацаагаар ажилладаг	<u>H</u>
	Хүнд зүйлийг өргөх, зөөх	<u>I</u>
	Давчуу, гүнзгий нүхэнд ажиллах	<u>L</u>
	Тэсрэх дэлбэрэх бодистой ажиллах	<u>M</u>
420	Ууланд алт олборлолт хийхдээ тэсэлгээг хэрхэн хийдэг вэ?	
	Өөрсдөө	<u>A</u>
	Тэсэлгээний тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар	<u>B</u>
	Тэсэлгээ хийхдээ туршлагажсан ХАМО нараар	<u>C</u>
	Бусад	<u>D</u>
421	Тэсэлгээний материалаа хаанаас худалдан авдаг вэ?	
	Орон нутгийн дэлгүүр, зах дээрээс	<u>A</u>
	Хувь хүмүүсээс	<u>B</u>
	Хотоос	<u>C</u>
	Тэсэлгээний тусгай зөвшөөрөлтэй байгууллагаас	<u>D</u>
	Бусад	
422	Тэсэлгээний бодистой холбоотой ямар асуудлууд байдаг вэ?	
	Үйлчилгээний өртөг өндөр	<u>A</u>
	Хууль бус учир олдоц ховор	<u>B</u>
	Аюултай	<u>C</u>
	Хадгалахад хэцүү	<u>D</u>
	Цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагуудаас торгодог	<u>E</u>
	Бусад	<u>F</u>
423	Тэсэлгээний асуудлыг яаж шийдвэл зохистой вэ?	
	Орон нутгийн компаниудад тэсэлгээ хийх эрх өгөх	<u>A</u>
	ХАМО нарыг тэсэлгээчний сургалтанд суулгаж бэлдэх	<u>B</u>
	Аюулгүй ажиллагааны дүрмэндээ тэсэлгээний талаар тодорхой бичиж, энэ талаар ХАМО иргэдийг сургах	<u>C</u>
424	Та олборлосон хүдрээсээ алтыг хэрхэн ялгаж авдаг вэ?	
	Өөрөө гар аргаар	<u>A</u>
	ХАМО компаний хүдэр баяжуулах цехээр	<u>B</u>
	Бусад	<u>C</u>
425	Та ахуйн нөхцөлд алт бариулахдаа мөнгөн ус хэрэглэдэг үү?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
426	Мөнгөн усаар алт бариулахдаа хаана хийдэг вэ?	
	Гэртээ нууцаар	<u>A</u>
	Хөдөө хээр	<u>B</u>
	Уурхай дээр	<u>C</u>
	Илүү гэр, амбаартаа	<u>D</u>
	Бусад	<u>E</u>
427	Хэрэглэдэг бол мөнгөн устай шороогоо хаана хаядаг вэ?	
	Ус руу	<u>A</u>
	Хөрс рүү	<u>B</u>

	Нүхэнд	<u>C</u>
	Хогын цэг дээр	<u>D</u>
	Бусад	<u>E</u>
5. ХАМО нарын орлого зарлагын байдал		
501	Та долоо хоногт/ сард дунджаар хэдэн грамм алт олдог вэ?	
502	Та алт олборлосноороо долоо хоногт/ сард дунджаар хэдэн төгрөгний орлого олдог вэ?	
503	Дээрх хэмжээний алтыг олборлохын тулд та хэдэн төгрөгний зардал гаргадаг вэ?	
504	Ямар улиралд алт олборлоход зардал их гардаг вэ?	
505	Та алтнаас олсон орлогоосоо хуримтлал үүсгэж чаддаг уу?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
506	Та алт олборлож эхэлснээсээ хойш зээл авсан уу?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
507	Зээл авсан бол ямар зорилгоор авсан бэ?	
	Байр орон сууц болон машин худалдан авах зорилгоор	<u>A</u>
	Ахуйн болон өрхийн хүнсний хэрэгцээндээ	<u>B</u>
	Хүүхдийн сургалтын төлбөрт	<u>C</u>
	Багаж тоног төхөөрөмж авахад	<u>D</u>
	Уулын ажлаа эхлүүлэх гарааны мөнгөтэй болоход	<u>E</u>
	Өрөө төлөхөд	<u>F</u>
508	Та олборлосон алтаа хаана борлуулдаг вэ	
	Дэлгүүрт	<u>A</u>
	Банкинд	<u>B</u>
	ХАМО компанид	<u>C</u>
	Явуулын ченжүүдэд	<u>D</u>
	Хот орж	<u>E</u>
	Гадаадынханд	<u>F</u>
	Бусад	<u>G</u>
509	Алт худалдан авч байгаа үнийн талаар та ямар бодолтой байдаг вэ?	
	Өндөр	<u>A</u>
	Боломжийн	<u>B</u>
	Муу	<u>C</u>
510	Таны бодлоор алт борлуулах хамгийн тохиромжтой арга юу вэ?	
	Орон нутгийн банкиндаа зарах	<u>A</u>
	Банкинд	<u>B</u>
	Хүдэр баяжуулах цехдээ зарах	<u>C</u>
	Ченжүүдэд зарах	<u>D</u>
	Бусад	<u>E</u>

Б-р хэсэг: ХАМО иргэдийн эрүүл мэндийн байдал ба эрүүл мэндийн үйлчилгээ		
Б01	Та өвдсөн үедээ ихэвчлэн хаана, хэнд ханддаг вэ?	
	Түргэн тусламж	<u>A</u>
	Сумын эмнэлэг	<u>B</u>
	Хувийн эмнэлэг	<u>C</u>
	Аймаг, улсын эмнэлгүүд	<u>D</u>
	Найз нөхөд, таньдаг хүндээ	<u>E</u>
	Лам, бариач нарт	<u>F</u>
	Хувиараа арга хэмжээ, эмчилгээ хийх	<u>G</u>
Б02	Та ихэвчлэн ямар төрлийн эрүүл мэндийн үйлчилгээ авдаг вэ?	
	Яаралтай түргэн тусламжийн	<u>A</u>
	Урьдчилан сэргийлэх үзлэг	<u>B</u>
	Дархлаажуулалт	<u>C</u>
	Ужиг, архаг өвчнөө эмнүүлэх	<u>D</u>
	Зөвлөгөө авах	<u>E</u>
Б03	Таньд алт олборлож эхэлснээс хойш ямар нэгэн өвчний зовиур илэрсэн үү?	
	Цээжээр хатгуулан, ханиалгах	<u>A</u>
	Чих шуугих	<u>B</u>
	Хавагнах	<u>C</u>
	Арьс загатнаж, тууралт гарах	<u>D</u>
	Шээс ойрхон хүрэх	<u>E</u>
	Ууц нуруугаар өвдөх	<u>F</u>
	Үе мөч өвдөх	<u>G</u>
	Бөөр өвдөх	<u>H</u>
	Зовиур илрээгүй	<u>I</u>
	Бусад	<u>L</u>
Б04	Танд эрүүл мэндийн тусламж авахад ямар бэрхшээл тулгардаг вэ?	
	Эрүүл мэндийн тусламж авах зай хол	<u>A</u>
	Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй	<u>B</u>
	Орон нутгийн харъяалалгүй	<u>C</u>
	Холбоо харилцаа хангалтгүй	<u>D</u>
	Санхүүгийн бэрхшээл	<u>E</u>
	Тээврийн хэрэгсэл дутмаг	<u>F</u>
	Бусад	<u>G</u>
Б05	Та алт олборлож байхдаа гэмтэж байсан уу?	
	Гэмтэл	<u>A</u>
	Осол	<u>B</u>
	Гэмтэж байгаагүй	<u>C</u>
Б06	Тийм бол хэдэн удаа орж байсан бэ?	
Б07	Хэрэв тийм бол хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай ямар осолд орж байсан бэ?	
	Чулуунд дарагдах	<u>A</u>
	Бэхэлгээний олс тасарч унах	<u>B</u>

	Нүхэнд унасан	<u>C</u>
	Тэсэлгээнд өртсөн	<u>D</u>
	Түлэгдсэн	<u>E</u>
	Тоног төхөөрөмжийн бүрэн бус байдал болон буруу хэрэглээнээс үүдсэн осол	<u>F</u>
	Угаартсан	<u>G</u>
	Бусад	<u>H</u>
Б08	Энд буюу таны ажилладаг уурхайд жилд хэдэн удаа хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой осол аваар гардаг вэ?	
Б09	Тэгвэл ямар төрлийн осол аваарууд энд голдуу тохиолддог вэ?	
	Чулуунд дарагдах	<u>A</u>
	Бэхэлгээний олс тасарч унах	<u>B</u>
	Нүхэнд унах	<u>C</u>
	Тэсэлгээнд өртөх	<u>D</u>
	Түлэгдсэн	<u>E</u>
	Тоног төхөөрөмжийн бүрэн бус байдал болон буруу хэрэглээнээс үүдсэн	<u>F</u>
	Угаартах	<u>G</u>
	Бусад	<u>H</u>
Б10	Уурхай дээр ажиллаж байхдаа шаардлагатай эм тариагаа хаанаас голдуу авдаг вэ?	
	Гэр дэлгүүрээс	<u>A</u>
	Өөртөө авч явдаг	<u>B</u>
	Хувь хүнээс	<u>C</u>
	Сумын төв рүү хүн явуулж	<u>D</u>
	Бусад	<u>E</u>
Б11	Таны бодлоор ослын шалтгаан юу вэ?	.
	Аюулгүй ажиллагааны дүрмийг мэддэггүйгээс	<u>A</u>
		.
	Аюулгүй ажиллагааны дүрэм нь амьдралд хэрэгжүүлэх боломжгүй	<u>B</u>
	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл дутмагаас	<u>C</u>
	Аюулгүй ажиллагааны дүрмийг мөрддөггүйгээс	<u>D</u>
	Бусад	<u>E</u>
Б12	Та уурхайд ажиллаж байх үедээ хамгийн хурдандаа хэдэн минутын дотор анхны тусламж авч чадах вэ?	
Б13	Та эрүүл мэндийн даатгалд хамрагдсан уу?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
Б14	Хамрагдаагүй бол яагаад?	
	Мөнгөний боломжгүй	<u>A</u>
	Орон нутгийн харъяалалгүй	<u>B</u>
	Иргэний бичиг баримт байхгүй	<u>C</u>
	Энэ талын мэдээлэл байхгүй	<u>D</u>

	Бусад	<u>E</u>
7-р хэсэг: Нийгмийн үйлчилгээ ба нийгмийн даатгал		
701	Та алтнаас олсон орлогоноосоо НДШ-ээ төлдөг үү?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
702	Үгүй бол яагаад?	
	Мөнгөний боломжгүй	<u>A</u>
	Орон нутгийн харъяалалгүй	<u>B</u>
	НД-д хамрагдахын ач холбогдолыг мэдэхгүй	<u>C</u>
	Нийгмийн даатгалын тогтолцоонд итгэдэггүй	<u>D</u>
	Энэ талын мэдээлэл байхгүй	<u>E</u>
	Бусад	<u>F</u>
703	Та сард хэдэн төгрөгний татвар төлдөг вэ?	
704	Үгүй бол яагаад?	
	Төлбөрийн чадваргүй	<u>A</u>
	Төлөх аргаа, хууль дүрмээ мэдэхгүй	<u>B</u>
	Завгүй	<u>C</u>
	Бусад	<u>D</u>
8-р хэсэг: ХАМО иргэдийн зохион байгуулалт, хамтын ажиллагаа		
801	Та Хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах түр журманд өгүүлсэн бүртгэгдээгүй нөхөрлөлийн талаар сонссон уу?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
802	Та өөрөө нөхөрлөлийн гишүүн мөн үү?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
803	Тийм бол ямар нөхөрлөлийн гишүүн бэ?	
804	Танай нөхөрлөл хэдэн гишүүнтэй вэ?	
805	Нөхөрлөлд орохын давуу талыг та юу гэж үздэг вэ?	
	Хөдөлмөр хөнгөвчилдөг	<u>A</u>
	Багаж хэрэгсэлээ хувааж хэрэглэж болдог	<u>B</u>
	Аюулгүй байдал сайжирдаг	<u>C</u>
	Мэдээлэл авах байдал сайжирдаг	<u>D</u>
	Нийгмийн халамж үйлчилгээ авахад дөхөмтэй	<u>E</u>
	Асуудлаа хамт олноороо шийддэг	<u>F</u>
	Асуудлаа дэвшүүлэхэд амар, хүчтэй байдаг	<u>G</u>
806	Нөхөрлөлийн гишүүд ашгаа хэрхэн хуваадаг вэ?	
	Тэгш хуваадаг	<u>A</u>
	Хийснээрээ авдаг	<u>B</u>
	Нөхөрлөлийн ахлагч ашиг хуваарилдаг	<u>C</u>
	Бусад	<u>D</u>
807	Нөхөрлөлийн гишүүдийн ашгаа хувааж байгаа байдалд та хэр сэтгэл хангалуун байдаг вэ?	
	Хангалуун	<u>A</u>
	Дундуур	<u>B</u>
	Муу	<u>C</u>

808	Танай нөхөрлөл олборлолтын үйл ажиллагааг хэрхэн санхүүжүүлдэг вэ?	
809	Танд өөрийн ажиллаж байгаа уурхайдаа дуртай газраа олборлолт хийх эрх бий юу?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
	Танай нөхөрлөлийн олборлолт хийдэг тунелын нэр юу вэ?	<u>C</u>
810	Хэрэв та нөхөрлөлд ороогүй бол яагаад?	
	Нөхөрлөлийн талаар сайн мэдэхгүй	<u>A</u>
	Нөхөрлөлд ороход өндөр шаардлага тавьдаг учир хэцүү байдаг	<u>B</u>
	Санаа нийлсэн хүмүүс байхгүй	<u>C</u>
	Ашгаа хуваах тал дээр асуудалтай	<u>D</u>
811	БУХ ТББ-ын талаар мэдэх үү?	
	Тийм	<u>A</u>
	Үгүй	<u>B</u>
812	ТББ юу хийдэг вэ?	
	ХАМО иргэдэд сургалт, сурталчилгааны ажил хийдэг	<u>A</u>
	ХАМО нарын эрх ашгийг хамгаалдаг	<u>B</u>
	ХАМО иргэдийн оролцоо, дуу хоолойг дэмждэг	<u>C</u>
	ХАМО нарын газрын асуудлыг зохион байгуулдаг	<u>D</u>
	Орлого нэмэгдүүлэхэд тустай	<u>E</u>
	ХАМО нарын дунд эрх тэгш байдлыг бий болгохоор ажилладаг	<u>F</u>
	Бусад	<u>G</u>
813	Таны байгаа уурхай дээр хамгийн хэрэгцээтэй зүйл юу вэ?	
	Тогтмол хэвлэл	<u>A</u>
	Халуун ус	<u>B</u>
	Цахилгаан	<u>C</u>
	Ундны ус	<u>D</u>
	Чөлөөт цагаа өнгөрөөх газар	<u>E</u>
	Банкны үйлчилгээ	<u>F</u>
	Үзвэр үйлчилгээ	<u>G</u>
	Жорлон, хогийн цэг	<u>H</u>
	Эмийн сан	<u>I</u>
	Бусад	<u>L</u>
814	Таны эрх ашгийг хамгийн ихээр хамгаалдаг байгууллага, хувь хүнийг нэрлэнэ үү?	
	Их хурлын гишүүд	<u>A</u>
	Орон нутгийн засаг захиргаа	<u>B</u>
	Уул Уурхайн аврах алба	<u>C</u>
	ТоБУТөсөл	<u>D</u>
	БУХ ТББ	<u>E</u>
	ХАМО компани	<u>F</u>

Төв аймгийн Борнуур сумын нийгэм эдийн засгийн суурь судалгаа

Иргэний хөдөлгөөнүүд	<u>Г</u>
Нөхөрлөлүүд	<u>Н</u>
Хувь хүний нэрийг бичнэ үү	<u>!</u>

Асуултанд хариулж, бидэнтэй хамтран ажилласан танд баярлалаа.

ХАВСРАЛТ 3

ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН УДИРДАМЖ

1. Танилцах

Судлаач тухайн ярилцлага авах хүндээ өөрийгөө болон судалгааны зорилгыг товч танилцуулж ярилцлага өгөгчийн овог нэр, хаягийг асуун санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх уур амьсгалыг бүрдүүлнэ.

2. Ярилцлага хөтлөгчийн анхаарах зүйлс:

Ярилцлагын эхэн үед судлаач нь хариулахад хялбар, энгийн асуултыг асуусны дараа ярилцлагыг цаашид өрнүүлэх асуулт руу орно. Ярилцагчаас аль болох нээлттэй асуулт асуух бөгөөд ярилцагч хүндээ санаа өгөх байдлаар асуух болон өөрийн санал бодлыг тулгахыг хориглоно.

Ярилцлагын төгсгөлд ярилцлагын гол асуултуудын жагсаалтыг шалгаж орхигдуулсан асуулт байвал асууна. Ярилцагчийн хэлсэн үгийн тэмдэглэлээс түүний санаа, бодлыг нэгтгэн танилцуулж хэрэв ярилцлагын явцад ойлгомжгүй үг хэллэг, хоёрдмол утгатай санаа гарсан бол тодруулна. Ярилцлага өгөгчид манай судалгаанд амжилттай оролцож өөрийн санал бодлыг илэрхийлсэн явдалд талархан түүний санал бодол төслийн цаашдын үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байгаагаа хэлж ярилцлагыг өндөрлөнө.

3. Түлхүүр асуултууд:

- **Борнуур сумын Засаг дарга**

1. Танай сум нийт хэдэн оршин суугчтай вэ? Үүний хэд нь нэн ядуу, ядуу амьдралтай вэ?
2. Сумын захиргааны зүгээс ядууралтай тэмцэх тал дээр ямар үйл ажиллагааг хийж байгаа вэ?
3. Сумын эдийн засгийн байдалд хувиараа алт олборлогчдын үзүүлж буй нөлөөг та юу гэж үздэг вэ? Яагаад?
4. Хувиараа алт олборлох үйл ажиллагаанаас суманд жилд хэдий хэмжээний орлого орж байгаа вэ? Энэ нь сумын хэмжээнд орж байгаа бусад орлоготой харьцуулахад ямар вэ?
5. Танай суманд хэдэн ХАМО иргэд байдаг вэ? Ямар аймаг сумдаас хүмүүс ирж ХАМО-лодог вэ?
6. Танай суманд хэдэн газарт хувиараа алт олборлож байгаа вэ?
7. Хувиараа алт олборлогчдыг та юу гэж бодож байна вэ? Яагаад?

8. Хувиараа алт олборлосноос танай сумын **байгаль орчинд** ямар нөлөө үзүүлж байгаа гэж та бодож байна вэ? Энэ тал дээр сумын удирдлагын зүгээс ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа вэ?
9. Хувиараа алт олборлосноор танай сумын **иргэд, хүүхэд, эмэгтэйчүүдэд** ямар нэг нөлөө үзүүлж байгаа юу?
10. Алт олборлосон газарт нөхөн сэргээлт хийсэн үү? Хэдэн га талбайд хийсэн бэ?
11. Танай сумын иргэд өөрсдөө хувиараа алт олборлодог уу? Яагаад?
12. Танай сумын ИТХ, ЗДТГ-ын зүгээс ХАМО иргэдийн талаар ямар бодлого, чиглэл барьж ажилладаг вэ?
13. ХАМО нарт нийгмийн ямар тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа вэ?
14. Танай суманд ХАМО иргэдийн алт олборлох үйл ажиллагаатай холбоотой осол ойролцоогоор жилд хэдэн удаа гардаг вэ?
15. Хувиараа алт олборлогчдын үйл ажиллагаа, газрын асуудлыг зохицуулж буй дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар та ямар санал бодолтой байна вэ?

• **Сумын нийгмийн ажилтан**

1. Танай сум нийт хэдэн оршин суугчтай вэ? Үүний нэн ядуу, ядуу, чинээлэг амьдралтай өрхийг хувиар илэрхийлнэ үү?
2. Танай суманд хэдэн ХАМО иргэд байдаг вэ? Тэдний хувиараа алт олборлох болсон шалтгааныг та юу гэж бодож байна? Үүнийг өрхийн амьжиргааны түвшингээр нь ангилбал нэн ядуу, ядуу, чинээлэг өрхийн эзлэх хувь нь хэд вэ? Өөр ямар аймаг сумдаас ХАМО иргэд ирсэн байдаг вэ?
3. Гаднаас ирсэн ХАМО иргэд болон сумын хувиараа алт олборлогчдын хооронд зөрчил хэр гардаг вэ? Гол шалтгаан нь юу вэ?
4. ХАМО нарын дунд нийгмийн ямар тулгамдсан асуудал байдаг вэ? /архидалт, биеэ үнэлэлт, гэмт хэрэг г.м/
5. Хувиараа алт олборлосноор танай сумын **иргэд, хүүхэд, эмэгтэйчүүдэд** ямар нэг нөлөө үзүүлж байгаа юу?
6. Ганц бие өрх толгойлсон хүн танай суманд хэр олон байдаг вэ? Тэдэнд алт олборлон амьжиргаагаа залгуулах, дээшлүүлэх боломж хэр байдаг вэ?
7. ХАМО нарт сумын зүгээс нийгмийн ямар тусламж, үйлчилгээг үзүүлж байгаа вэ?
8. Нийгмийн халамж, нийгмийн даатгал зэрэг асуудлуудын талаар ХАМО нарын дунд та өөрийн зүгээс сургалт сурталчилгааны ажлуудыг хийж байсан уу? Аль чиглэлээр, хэрхэн хийж байсан бэ?

• **Сумын эмнэлгийн эрхлэгч**

1. *ХАМО иргэдийн дунд зонхилон тохиолддог эрүүл мэндийн асуудал нь юу вэ?*
2. *Тэдний дунд ямар төрлийн өвчлөл их байдаг вэ? Өвчлөлийн шалтгааныг та юу гэж бодож байна вэ?*
3. *Хөдөлмөрийн аюулгүй байдлаас болж сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн чадвараа алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан иргэдийн тоог хэлнэ үү? Та хүйсээр нь ангилж хэлж өгнө үү?*
4. *ХАМО иргэдээс хэдэн хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдаг вэ? Хамруулахын тулд танай эмнэлгийн байгууллагын зүгээс юу хийсэн бэ?*
5. *Яаралтай тусламжийн дуудлага авсан тохиолдолд сумын эмнэлгийн зүгээс хэдий хугацааны дотор эмнэлгийн анхны тусламжийг хүдэр олборлож буй ХАМО иргэдэд үзүүлж чаддаг вэ?*
6. *Эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй хүргэхэд ямар хүндрэлүүд гардаг вэ? Үүнийг хэрхэн шийдвэрлэсэн бэ? Шийдвэрлэхээр төлөвлөж байгаа вэ?*
7. *Хувиараа алт олборлож байгаа эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрүүл мэндийн байдал ямар байдаг вэ? Эмнэлгийн ажилтны хувьд санаа зовоосон зүйл байдаг уу? Тийм бол ямар?*
8. *ХАМО нарын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаанаас шалтгаалан танай сумын нутагт сүүлийн жилүүдэд тохиолдсон хүний амь нас эрсдэх, гэмтэх зэрэг тохиолдлуудын шалтгаан, түүнээс улбаалан гарсан хохирлын талаар ярина уу? Шороонд дарагдах, агаар дутагдах зэргээр хүний амь нас хохирсон тохиолдолд хэрэг бүртгэлийг хаанаас хариуцан явуулдаг вэ? Энэ асуудлаас гарсан хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ? Дахин энэ төрлийн тохиолдол гарахаас сэргийлэх талаар ямар арга хэмжээ авсан бэ?*

• **Сумын байгаль орчны байцаагч**

1. *Танай суманд хэдэн ХАМО иргэд байдаг вэ? Өөр ямар аймаг сумдаас ирсэн бэ?*
2. *Танай суманд хэдэн газарт хувиараа алт олборлож байгаа вэ?*
3. *Танай суманд албан ёсны зөвшөөрөлтэй хэдэн нөхөрлөл байдаг вэ? Эдгээр нөхөрлөлд ойролцоогоор хэдэн га газар ашиглагддаг вэ?*
4. *Танай сумын хэдэн га газар хайгуулын лицензтэй вэ?*
5. *Танай сумын хэдэн га газарт олборлолтын лицензтэй вэ?*
6. *Хувиараа алт олборлосноос танай сумын **байгаль орчинд** ямар нөлөө үзүүлж байгаа гэж та бодож байна вэ? Жишээ татна уу*
7. *Байгалийн нөхөн сэргээлт хэр хийгдэж байгаа вэ?*
8. *Орон нутгийн байгаль хамгаалагч нар гар аргаар алт олборлогчдын үйл ажиллагаанд хяналт тавьж тэдний байгаль*

орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгахад ямар эрх үүрэгтэйгээр оролцдог вэ? Үүнд гардаг бэрхшээл болон давуу тал байвал хэлнэ үү?

9. Хувиараа алт олборлогчдын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах талаар тэдэнд зориулж танай байгууллагын зүгээс явуулсан мэдээлэл, сургалтын талаар ярьж өгнө үү?
10. Танай суманд хэрэглэж байгаа мөнгөн ус хэрэглэхгүйгээр хүдэр баяжуулах технологийн талаар та юу гэж бодож байна вэ? Үүний давуу болон сул тал нь юу байна вэ?

- **ХАМО компаний удирдлага**

1. ХАМО иргэдтэй ажиллахад гарч буй хүндрэлүүд юу вэ? Ямар тохиолдлууд гардаг талаар та бидэнд тодорхой жишээ татаж ярина уу?
2. ХАМО нарын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талаар танай байгууллага юу хийсэн болон хийхээр төлөвлөж байна вэ?
3. Шаардлагатай тохиолдолд ХАМО иргэдэд хамгаалалтын болон бусад тусламжийг үзүүлж байсан уу? Үзүүлэх боломж бий юу?
4. Мөнгөн ус хэрэглэхгүйгээр хүдэр баяжуулах технологийн талаар та юу гэж бодож байна вэ? Үүний давуу болон сул тал нь юу байна вэ?
5. ХАМО нарын нөхөрлөлтэй хэрхэн хамтран ажиллаж байгаа вэ? Гарч буй хүндрэл бэрхшээл байна уу?
6. ХАМО нарын нөхөрлөлийн талаар таны бодол юу вэ? Юуг анхаарах хэрэгтэй гэж та бодож байна вэ?

- **БУХ ТББ-ын удирдах зөвлөл, гишүүд**

1. Танай ТББ-ын зорилго юу вэ? Хэдэн гишүүнтэй вэ?
2. Зорилгоо биелүүлэхийн тулд ямар үйл ажиллагаа явуулж байна вэ?
3. Гишүүддээ үзүүлж буй гол үйлчилгээ чинь юу вэ?
4. ХАМО иргэдийн дунд тохиолддог нийтлэг бэрхшээл юу вэ? Хэрхэн шийдэж болохоор санагддаг вэ?
5. ХАМО иргэдийн асуудлуудыг шийдвэрлэхийн тулд сумын засаг захиргаатай хэрхэн хамтарч ажилладаг вэ?
6. ХАМО иргэдийн нийгмийн оролцоог та хэрхэн үнэлэх вэ? Яагаад?
7. Танай байгууллагын үйл ажиллагаанд нөхөрлөлийн гишүүд болон энгийн ХАМО нар хэрхэн оролцдог вэ?
8. Танай байгууллага ХАМО компанитай хэрхэн хамтарч ажилладаг вэ? Гарч байсан хүндрэлүүд юу вэ?
9. Танай байгууллагын удирдлагын зүгээс ХАМО иргэдийг нэгдсэн нэг зохион байгуулалттай болгож тэдний эрх ашгийн төлөө ажиллахад ямар хүндрэлүүд гардаг вэ?

10. *ХАМО иргэдийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэхэд танай байгууллагын зүгээс ямар зүйл хийсэн бэ? Гардаг бэрхшээлүүд юу вэ?*

ХАВСРАЛТ 4

БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГЫН УДИРДАМЖ

Бүлгийн ярилцлагад дараах бүлэг хүмүүсийг хамруулна:

- ХАМО эрэгтэйчүүд
- ХАМО эмэгтэйчүүд
- Борнуур сум дах үйлчилгээний салбарын ажилчид
- Борнуур сумын энгийн иргэд

1. Танилцах

Судлаач бүлгийн ярилцлаганд оролцогсдод судалгааны багийн гишүүд нь судалгааны зорилгыг товч мэдээлсний дараа ярилцлаганд оролцогсодтой танилцана.

2. Бүлгийн ярилцлагын үед анхаарах зүйлс:

Ярилцлага эхлэх үед чиглүүлэгч нь хариулахад хялбар, энгийн асуултыг асуусны дараа ярилцлагыг цаашид өрнүүлэх асуулт руу орно. Оролцогсдоос аль болох нээлттэй асуулт асуух бөгөөд тэдэнд санаа өгөх байдлаар асуух болон өөрийн санал бодлыг тулгахыг хориглоно.

Ярилцлагын хөтлөгч нь БЯ-ны үед оролцогсдыг адил тэгш оролцуулах бөгөөд бусдыгаа хэт давамгайлаад байгаа хүнийг ажиглагч авч гарч ганцаарчилсан ярилцлага хийнэ.

Ярилцлаганы төгсгөлд оролцогсдод судалгаанд амжилттай оролцож өөрийн санал бодлыг илэрхийлсэн явдалд талархан түүний санал бодол төслийн цаашдын үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байгаагаа хэлж ярилцлагыг өндөрлөнө.

3. Түлхүүр асуултууд:

- **ХАМО эмэгтэйчүүд**

- 1. Таны хувиараа алт олборлох болсон шалтгаан юу вэ? Хэр удаан олборлож байна вэ?*
- 2. Танай гэр бүлийн гишүүдээс хэдэн хүн энэ уурхайд ажиллаж байгаа вэ? Хүүхдүүд чинь тусалдаг уу? Тусалдаг бол жилд хэдий хугацаагаар энэ уурхайд ирдэг вэ? Гэр бүлээс хол байхад гардаг гол бэрхшээлүүд юу байдаг вэ?*

3. Та алт олборлоход яг ямар ажлыг нь гүйцэтгэдэг вэ? (нүх ухдаг уу, шороогоо гаргадаг уу, шороогоо угаадаг уу, зардаг уу гэх мэт)
4. Алт хувиараа олборлоход хамгийн хүнд хэцүү ажил нь юу вэ? Энэ ажлыг хэдэн насны, ямар бие бялдартай хүмүүс хийдэг вэ? Яагаад?
5. Мөнгөн ус хэрэглэхгүйгээр хүдэр баяжуулах технологи танд ямар санагдаж байна вэ?
6. Та гэр бүл руугаа мөнгө явуулдаг уу? Сард хэр зэргийг явуулдаг вэ? Танай гэр бүлийн сарын орлогын хэдэн хувь нь таны алт олборлосноос олсон орлого байдаг вэ?
7. Та хүмүүстэй нийлж бригад/баг болж ажилладаг уу? Ажилладаг бол орлогоо хэрхэн хуваадаг вэ? Орлогоо хуваарилахад эмэгтэй хүний хөдөлмөрийг багаар үнэлэх тохиолдол байдаг уу?
8. Жирэмсэн, мөн бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд болон 18 нас хүрээгүй хүүхдүүд хэр их хувиараа алт олборлодог вэ?
9. Алт зарахад ямар хууль эрх зүйн болон эдийн засгийн зохицуулалт байгаагаар гэж та бодож байна вэ?
10. ХАМО нарын эрүүл мэндийн байдал ямар байдаг вэ?
11. Аваар осол хэр элбэг гардаг вэ? Урьдчилан сэргийлж болох уу?
12. Осол гарсан тохиолдолд хэнд, хэрхэн хандаж хэдийн хугацаанд тусламж авч байсан бэ? Эмнэлгийн тусламж дунджаар хэдий хугацааны дотор ирж байсан бэ?
13. Та осолд өртсөн хүнд анхны тусламж үзүүлж байсан уу?
14. Та өөрийн аюулгүй байдлаа хэр хангагдсан гэж үздэг вэ?
15. Таны цаашдын төлөвлөгөө юу вэ?

• **Борнуур сум дах худалдаа, үйлчилгээний салбарын ажилчид**

1. Та өөрийн энэ үйлчилгээ, худалдааг хэр удаан эрхэлж байгаа вэ?
2. Борнуур сумын иргэдийн худалдан авах чадварыг та ямар гэж үнэлэх вэ?
3. Ямар төрлийн ажил эрхэлж буй хүмүүсийн худалдан авах чадвар өндөр байдаг вэ? Яагаад гэж та бодож байна?
4. ХАМО иргэд танаас зээлээр бараа авах тохиолдол байдаг уу?
5. Сумын иргэд хувиараа алт олборлодог уу?
6. Сумын иргэдийн ХАМО иргэдэд хандах хандлага ямар байдаг вэ?

• **Борнуур сумын энгийн иргэд**

1. Та энэ суманд хэр удаан оршин сууж байгаа вэ?
2. Хувиараа алт олборлогчдыг та юу гэж бодож байна вэ? Яагаад?
3. Сүүлийн жилүүдэд ХАМО иргэд танай суманд үзэгдэх болсноор та бүгдийн өдөр тутмын амьдралд ямар нөлөө үзүүлж байгаа гэж та бодож байна? Жишээ татна уу?

4. Хувиараа алт олборлосноос танай сумын **эдийн засгийн** байдалд ямар нөлөө үзүүлж байгаа гэж та бодож байна вэ?
5. Хувиараа алт олборлосноос танай сумын **байгаль орчинд** ямар нөлөө үзүүлж байгаа гэж та бодож байна вэ?
6. Хувиараа алт олборлосноор танай сумын **хүүхэд, эмэгтэйчүүдэд** ямар нэг нөлөө үзүүлж байгаа юу?
7. Сумын иргэд болон ХАМО иргэдийн дунд ямар нэг зөрчил гардаг уу? Жишээ татна уу? Зөрчлийн шалтгаан нь юу гэж бодож байна вэ?
8. Танай сумын иргэд өөрсдөө хувиараа алт олборлодог уу? Яагаад?
9. Хувиараа алт олборлоход ямар хууль эрх зүйн зохицуулалт байх ёстой гэж та бодож байна вэ? Үүнийг хэн хариуцах ёстой вэ?

---oOo---